



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН 2025



“Ухаа худагийн нэг өдөр” комик зураг, 2026

Агуулга



Хонгорын элс, Сэврэй сум, Өмнөговь аймаг

1. ОРШИЛ 03

Компанийн ерөнхий мэдээлэл
Гүйцэтгэх захирлын зурвас

2. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО БА МЕНЕЖМЕНТ 08

БОНЗ-ын материаллаг байдлын үнэлгээ
Тогтвортой хөгжлийн зорилтуудтай нийцсэн байдал
БОНЗ-ын үнэлгээ, аудит

3. БАЙГАЛЬ ОРЧИН 13

Нөхөн сэргээлт ба ногоон байгууламж
Биологийн олон янз байдлын хамгаалал
Агаарын чанар
Хог хаягдлын менежмент
Усны менежмент
Эрчим хүчний хэрэглээ ба хэмнэлт
Уур амьсгалын өөрчлөлт ба хүлэмжийн хийн ялгарлын тооцоолол

4. НИЙГЭМ 23

Ажиллагсад
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
Ханган нийлүүлэлтийн бодлого ба менежмент
Оролцогч талуудын хамтын ажиллагаа
Орон нутгийн хөгжил ба төсөл, хөтөлбөрүүд
Шагнал

5. ЗАСАГЛАЛ 42

Компанийн засаглал
Авлигаас ангид байх зарчим
Аудит ба нийцэл
Ил тод байдал

6. ХАВСРАЛТ 45

Тайлагналын олон улсын стандарт (GRI) индекс
БОНЗ тогтвортой байдлын тайлагналын удирдамж

1. Оршил

Энержи Ресурс компани нь хариуцлагатай уул уурхайн зарчмыг үйл ажиллагааныхаа цөм болгон ажилладаг. Энэхүү тайлангаар дамжуулан бид 2025 оны Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын үйл ажиллагааны үр дүн, тогтвортой хөгжлийн бодлогын хэрэгжилт болон голлох үзүүлэлтүүдийг оролцогч талуудад нээлттэй, дэлгэрэнгүй танилцуулахыг зорьсон болно. Тайлангийн мэдээллийг Тайлагналын олон улсын санаачилга (GRI) болон уул уурхайн салбарт мөрдөгдөж буй БОНЗ-ын стандартууд, Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооноос боловсруулсан БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамж зэрэгтэй уялдуулан бэлтгэв.





Хэрмэн цав, Гурвантэс сум, Өмнөговь аймаг

Эрхэм зорилго

Бид орчин үеийн техник, технологийг мэргэшсэн боловсон хүчний ур чадвар, хүсэл тэмүүлэлтэй хослуулан Монгол Улсын хөгжил, эдийн засгийн есөлтөд хувь нэмрээ оруулна.

Үнэт зүйлс

Ажиллагсад, боловсон хүчин манай компанийн амин чухал зүйл гэж бид үздэг, иймд:

- Энержи Ресурс ХХК нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчинд нэн тэргүүнд анхаарна.
- Энержи Ресурс ХХК нь ур чадвар, ажлын үр дүнг харгалзсан хөдөлмөр эрхлэлтийн адил тэгш боломжоор хангаж, хариуцлагатай ажил олгогч байна.

Орчин үеийн өндөр үр өгөөжтэй техник технологи нь Монгол Улсад хөгжил дэвшил авчирна гэдэгт бид итгэдэг, иймд:

- Энержи Ресурс ХХК нь сайн чанарын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг дэлхийн түвшний нүүрсний уурхай байгуулж хөгжүүлнэ.
- Энержи Ресурс ХХК нь Монгол Улсын нүүрс олборлолтын салбарт техникийн шинэ стандарт тогтоохыг зорин.

Бид байгаль орчны хариуцлагатай уурхайн үйл ажиллагаа явуулдаг, иймд:

- Энержи Ресурс ХХК-ийн уурхай, дагалдах инженерийн бүтцийг байгаль орчинд аль болохоор

Алсын хараа

Бид олон улсын зах зээл дээр нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүн борлуулах дэлхийн хэмжээний үйл ажиллагаатай үйлдвэрлэгч компани болно. Компани нь Монгол Улсад өндөр чанартай коксжих нүүрс үйлдвэрлэж, экспортолдог үндэсний уул уурхайн компани юм.

бага нөлөөлөл учруулахаар зохион байгуулна.

- Энержи Ресурс ХХК нь байгаль орчны шаардлагатай бүх стандартуудыг мөрдөж, байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авна.

Бид нийгмийн хариуцлагатай уурхайн үйл ажиллагаа явуулдаг, иймд:

- Энержи Ресурс ХХК нь иргэд, засаг захиргааны байгууллага, харилцагч, нийлүүлэгчидтэй "сайн хөрш"-ийн харилцааг хөгжүүлнэ.
- Энержи Ресурс ХХК нь иргэдэд чиглэсэн бодлого, хөтөлбөрүүдээр дамжуулан нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулна.

Компанийн сайн засаглал нь Энержи Ресурс ХХК-ийг ажиллуулах, удирдах, хяналтыг хэрэгжүүлэх үзэл баримтлал гэж бид үздэг, иймд:

- Энержи Ресурс ХХК нь олон улсын шилдэг туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.
- Энержи Ресурс ХХК нь компанийн засаглалын соёлыг байгууллагынхаа хөгжлийн салшгүй хэсэг болгон мөрдөнө.

Компанийн тухай

Энержи Ресурс ХХК нь 2005 онд Монгол Улсад байгуулагдсан үндэсний уул уурхайн компани бөгөөд 2009 оноос эхлэн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах Ухаа худаг нүүрсний уурхайд үйл ажиллагаа явуулж ирлээ. Өнөөдрийн байдлаар, Энержи Ресурс ХХК нь нүүрсийг дотооддоо угааж баяжуулан экспортолж буй Монгол Улсын голлох аж ахуйн нэгж бөгөөд ингэснээр Монгол нүүрсний

үнэ цэнэ, олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлсээр байна. Тус компани шууд болон шууд бусаар нийт 7,800 орчим хүнийг ажлын байраар хангаж, үндэсний 2,500 гаруй аж ахуйн нэгжтэй урт хугацааны тогтвортой хамтын ажиллагааг хэрэгжүүлж ирсэн. Компани нь татвар төлөлт, нийгмийн хариуцлагаар Монгол Улсын ТОП 10 аж ахуйн нэгжийн тоонд үйл ажиллагаа явуулж эхэлснээс

хойш тасралтгүй 17 жилийн турш багтаж ирсэн. Мөн 2010 онд Монголын үндэсний компаниудаас анх удаа Хонконгийн хөрөнгийн биржид амжилттай IPO хийж, олон улсын хөрөнгийн зах зээлд хувьцаагаа гарган нээлттэй хувьцаат компани болсон бөгөөд хувьцааны хяналтын багцыг дотоодын хөрөнгө оруулагчид эзэмшдэг. Төвөөс алслагдмал говийн бүс нутагт Монгол Улсад анхдагч Нүүрс баяжуулах

үйлдвэр, цахилгаан станц, ус хангамжийн системийг байгуулснаас гадна 800 айлын орон сууц, 1,000 гаруй хүүхэд хүлээн авах сургууль, цэцэрлэгийн цогцолборыг дэд бүтэцтэй нь барьж байгуулсан. Мөн орон нутгийн иргэдийг сургаж, мэргэшүүлэн ажлын байраар хангаж, сум орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд урт хугацааны бодит дэмжлэг үзүүлж байна.



Компанийн үзүүлэлтүүд (2025)

ТОП-100 Аж Ахуйн Нэгжийн шалгаруулалт (2025)

II байр

Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн
үйлдвэрлэл (2011-2025)

79 сая тонн

Хөрөнгө оруулалт (2009-2025)

+\$1 тэрбум

Урт хугацаанд хамтрагч
аж ахуйн нэгжүүд (2009-2025)

+2,500

Байгаль орчин

10 га

Нөхөн сэргээсэн талбай

+126,000

Амжилттай ургуулсан мод сөөг

1,385,678 м³

Дахин ашигласан усны хэмжээ

Нийгэм

+7,800

Шууд ба шууд бус ажлын байр

₮512 тэрбум

Татвар, хураамж

16.4 сая

Аюулгүй ажилласан хүн/цаг

Засаглал

99%

Байгаль орчны удирдлага болон
хууль, эрх зүйн хэрэгжилтийн
хөндлөнгийн үнэлгээний дүн

43%

ТУЗ-д хараат бус гишүүдийн эзлэх
хувь

“0”

Авлига, хээл хахуулийн зөрчил

Гүйцэтгэх захирлын зурвас



Монгол Улсын уул уурхайн салбар нь дэлхийн чиг хандлага, сорилттой хөл нийлүүлэн хөгжихийн зэрэгцээ байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын шаардлагад нийцсэн, хариуцлагатай үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь салбарын тогтвортой хөгжлийн үндсэн зорилт хэвээр байна. Энержи Ресурс ХХК нь энэ зорилтын хүрээнд үйл ажиллагааныхаа бүхий л түвшинд тогтвортой хөгжлийн зарчмыг нэвтрүүлж, бодит үр дүн гарган ажилласаар байна.

Манай компани ажиллагсдынхаа аюулгүй байдал, эрүүл мэнд, сайн сайхан байдлыг нэн тэргүүнд тавьж, тэгш боломж бүхий ажлын орчныг бүрдүүлж ирсэн. 2025 онд 16.4 сая хүн/цаг ажиллаж, гэмтлийн давтамж сүүлийн 5 жилийн дунджаас 20 хувиар буурсан нь бидний зорилтын бодит үр дүн юм. Мөн ажилтнуудыг орон нутагт ая тухтай амьдрах, тогтвортой суурьших нөхцөлийг илүү өргөжүүлэх зорилгын хүрээнд "Цэций хороолол 2А" төслийн эхний 150 айлын орон сууцыг ашиглалтад орууллаа.

Бид байгаль орчны тогтвортой байдлыг хангахад тууштай анхаарч, үйл ажиллагаанаас үүсэх нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлж байна. Ус бол манай үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн төдийгүй Монгол Улсын үнэт нөөц тул хэрэглээний үр ашгийг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарч ирсэн. 2025 онд Нүүрс баяжуулах үйлдвэрийн дэргэдэх Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрийн өргөтгөлийг амжилттай хэрэгжүүлснээр үйлдвэрийн усыг дахин ашиглах түвшинг хоёр дахин нэмэгдүүлж чадлаа. Мөн Ухаа худаг уурхайн үйл ажиллагаанд ISO 46001:2019 Усны хэрэглээний үр ашгийн менежментийн системийг амжилттай нэвтрүүлсэн нь бидний байгаль орчны хариуцлагыг илэрхийлэх чухал алхам боллоо.

Бид 2017 оноос хойш хүлэмжийн хийн ялгарлыг тооцож тайлагнаж буй Монголын анхдагч компаниудын нэг бөгөөд 2023 онд олон улсын хараат бус баталгаажуулалтад хамрагдсан. 2025 онд хараат бус үнэлгээг дахин амжилттай хийлгэж, хүлэмжийн хийн тооцооллыг ISO14064-1:2018 болон WRI/WBCSD хүлэмжийн хийн стандартуудын дагуу тооцоолж, ISO 14064-3:2019 стандартаар баталгаажуулсан. Цаашид ялгарлыг бууруулах бодит арга хэмжээг хэрэгжүүлэхэд энэхүү үр дүнг суурь болгон ажиллана.

Бид нийгмийн хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагааг тууштай хэрэгжүүлж, орон нутгийн иргэд, төрийн байгууллагуудтай харилцан ашигтай, урт хугацааны түншлэлийг хөгжүүлэхийг эрмэлздэг. Орон нутгийн хөгжлийн хөтөлбөрүүд болон олон төрлийн санаачилгын хүрээнд нийгмийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулсаар байна.

Сайн засаглал нь манай компанийн үйл ажиллагааны үндэс суурь бөгөөд бид олон улсын шилдэг туршлагад тулгуурлан засаглалын соёлыг байгууллагын хөгжлийн салшгүй хэсэг болгон төлөвшүүлж байна. Ил тод байдал, хариуцлага, ёс зүйг эрхэмлэсэн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх замаар бид тогтвортой өсөлт хангахыг зорьж байна.

Цаашид Энержи Ресурс ХХК нь БОНЗ-ын зарчмыг үйл ажиллагааныхаа салшгүй хэсэг болгон хөгжүүлж, хариуцлагатай ажил олгогч байж, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулахын төлөө үргэлжлүүлэн тууштай ажиллах болно.


Д.ЭНХБАТ
Гүйцэтгэх захирал

2. Тогтвортой хөгжлийн бодлого ба менежмент

Компанийн зүгээс БОНЗ-ын бодлого, стратеги, түүний хэрэгжилт, гүйцэтгэлийн үнэлгээ, хяналт болон тайлагналд өндөр ач холбогдол өгч ажилладаг. Группийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-ийн дэргэд БОНЗ-ын асуудал хариуцсан бие даасан хороо ажилладаг бөгөөд бодлого, стратегийн чиглэл, гүйцэтгэлүүдийг жил бүр ТУЗ-ийн түвшинд хэлэлцэн хянаж, баталгаажуулж байна. Мөн Гүйцэтгэх захирлаар ахлуулсан БОНЗ-ын Менежментийн хороо болон БОНЗ-ын хэрэгжилт хариуцсан бие даасан алба, нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Дэлхий даяар БОНЗ-ын стандарт, шаардлагууд нарийсахын хэрээр компанийн зүгээс материаллаг байдлын үнэлгээ, эрсдлийн тооцоолол, цаг уурын өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт, стратеги, хүлэмжийн хийн ялгарлын тооцоолол, түүнийг хэрхэн бууруулахад чиглэсэн тооцоо, төлөвлөлт, БОНЗ-ын удирдлагад онцгой анхаарал хандуулж ирлээ. Тухайлбал, шинжлэх ухаанд суурилсан тогтвортой хөгжлийн зорилтуудыг тодорхойлох үүднээс ISO 14068-1:2023 “Climate Change Management – Transition to Net Zero” стандартыг нэвтрүүлэхээр төлөвлөж байна. Бид дэлхий даяар уул уурхайн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн “Towards sustainable mining” буюу “Тогтвортой уул уурхайн төлөөх” (TSM) хөтөлбөрт Монголоосоо анх удаа бие даан хамрагдаж, хөндлөнгийн үнэлгээ гаргуулсан бөгөөд 2026 онд энэхүү стандартын дагуух өөрийн үнэлгээг гурав дахь удаагаа хийх юм. Түүнчлэн, 2025 оны тухайд хүлэмжийн хийн тооцооллын хөндлөнгийн баталгаажуулалтыг хийлгэх, БОНЗ-ын зорилтуудыг илүү нарийн, оновчтой тодорхойлох, оролцогч, сонирхогч талуудтай харилцах нээлттэй, хүртээмжтэй харилцааг сайжруулах чиглэлд тодорхой үе шаттайгаар төлөвлөлт хийн ажиллаж байна.

БОНЗ-ын материаллаг байдлын үнэлгээ

Энержи Ресурс компанийн материаллаг байдлын үнэлгээг байгууллагын дотоод бодлого, стратеги, үйл ажиллагааны чиглэл, мөн уул уурхайн салбарын ирээдүйн сорилт, боломжуудыг цогцоор нь харгалзан боловсруулсан болно. Дараах материаллаг байдлын үнэлгээ нь компанийн зүгээс тэргүүлэх ач холбогдол өгч буй чиглэлүүдийг байгаль орчин, нийгэм, эдийн засаг болон оролцогч талуудад үзүүлэх нөлөөллөөр нь харьцуулан тодорхойлсон бөгөөд БОНЗ-ын стратегийн голлох чиглэл болж байна.



1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй ба байгаль орчин
2. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицолт
3. Хүлэмжийн хийн ялгаруулалт
4. Авлигаас урьдчилан сэргийлэлт
5. Усны менежмент
6. Биологийн олон янз байдал
7. Хог хаягдлын менежмент
8. Ялгаварлан гадуурхалтаас ангид байх ба тэгш боломж
9. Орон нутгийн харилцаа
10. Хаягдлын далангийн менежмент
11. Ажиллах хүчний бодлого, практик
12. Агаарын чанар
13. Ханган нийлүүлэгчид
14. Нийгэм, эдийн засгийн нийцтэй үйл ажиллагаа
15. Албадан хөдөлмөр эрхлэлтийг үл тэвчих

Тогтвортой хөгжлийн зорилтуудтай нийцсэн байдал

Компанийн тогтвортой хөгжлийн төлөөх стратеги нь Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Тогтвортой Хөгжлийн Зорилтууд (ТХЗ), түүний үндсэн мөн чанарт суурилсан байдаг. Бид ТХЗ-д илүү бүтээлчээр, бодитой хувь нэмэр оруулахын тулд хамгийн чухал, хамаарал бүхий зорилтуудыг тодорхойлсон байдаг.

Бид зорилтуудаа жилээс жилд илүү нарийвчлан тодорхойлохыг зорьж буй бөгөөд ингэснээр өөрийн үйл ажиллагаагаар дамжуулан улс орон, дэлхий нийтийн нийтлэг зорилтод бодитой хувь нэмэр оруулан ажиллах юм.

Орон нутаг



Байгаль орчин



Ажиллагсад



Засаглал



БОНЗ-ЫН ҮНЭЛГЭЭ, АУДИТ

2025 онд компани дотоодын болон олон улсын хөндлөнгийн, сайн дурын олон үнэлгээ, аудитад хамрагдаж, өөрсдийн үйл ажиллагаандаа үнэлэлт, дүгнэлт хийлээ.



Towards Sustainable Mining (TSM)

2023 онд бид Канадын уул уурхайн ассоциациас дэлхийн олон улс оронд хэрэгжүүлж, хүлээн зөвшөөрөгдсөн "Towards Sustainable Mining" (TSM) буюу Тогтвортой Уул уурхайн үнэлгээний хөтөлбөрт хамрагдаж, Үйл ажиллагааны өөрийн үнэлгээг Ассоциациас хараат бус байдлаар, бие даан гүйцэтгэж, тайлагнасан анхны олон улсын компани юм. 2025 оны 7-р сард бид хоёр дахь жилдээ өөрийн үнэлгээг хийсэн бөгөөд шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ тогтвортой сайжирсаар байна. Манай үнэлгээ Канадын Уул уурхайн Холбооны (Mining Association of Canada) вэбсайт дээр, олон нийтэд нээлттэй байршиж байна.

[Mongolian Mining Corporation - The Mining Association of Canada](#)

TSM үнэлгээний хүснэгт

	Шалгуур үзүүлэлтүүд	2023 Өөрийн үнэлгээ	2024 Баталгаажсан үнэлгээ	2025 Өөрийн үнэлгээ
ХАБ ба эрүүл мэнд	Үүрэг амлалт ба хариуцлага	AAA	AAA	AAA
	Төлөвлөлт ба хэрэгжилт	AA	AAA	AAA
	Сэтгэлзүйн аюулгүй байдал, хүндлэлт зан төлөвийн харилцаа	-	-	A
	Сургалт, зан төлөв, соёл	AA	AAA	AAA
	Хяналт ба тайлагнал	A	AAA	AAA
	Үр дүн, үзүүлэлт	AA	B	B
Биологийн олон янз байдал	Үүрэг амлалт ба хариуцлага	AAA	AAA	AAA
	Төлөвлөлт ба хэрэгжилт	AA	AAA	AAA
	Тайлагнал	AAA	AAA	AAA
Усны зохистой менежмент	Засаглал	A	A	A
	Удирдлага	A	A	A
	Усны сав газрыг хамарсан төлөвлөлт	B	AA	AA
	Тайлагнал ба үр дүн	A	A	A
Уур амьсгалын өөрчлөлт	Компанийн түвшний уур амьсгалын өөрчлөлтийн менежмент	A	A	A
	Уурхайн нэгжийн түвшний уур амьсгалын өөрчлөлтийн менежмент	A	AA	AA
	Уурхайн нэгжийн түвшний зорилтот түвшин болон тайлагнал	B	C	C
Хүүхдийн хөдөлмөр болон албадан хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх	Албадан хөдөлмөрөөс сэргийлэх	-	Y	Y
	Хүүхдийн хөдөлмөрөөс сэргийлэх	-	Y	Y
Нутгийн иргэд болон орон нутгийн харилцаа	Оролцогч талуудыг тодорхойлох	A	B	AA
	Оролцогч талуудын үр дүнтэй хамтын ажиллагаа, харилцааны хэлбэрүүд	A	AA	A
	Уугуул иргэд	-	-	-
	Эерэг, сөрөг нөлөөллийн менежмент	A	B	B
	Оролцогч талуудын санал, гомдол шийдвэрлэх механизм	A	AA	A
Хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөлт	Хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөлт (Компанийн түвшинд)	-	Y	Y
	Хяналт	-	Y	Y
	Сургалт	-	Y	Y
	Хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөлт (Уурхайн нэгжийн түвшинд)	Y	Y	Y
	Хяналт	Y	Y	Y
	Сургалт	Y	N	N
Хаягдлын менежмент	Бодлого ба амлалт	-	c	c
	Хариуцлага ба үүрэг	-	c	c
	Систем ба онцгой байдлын бэлэн байдал	-	c	c
	Үйл ажиллагааны менежментийн системийн гарын авлага	-	c	c
	Менежментийн үнэлгээ	-	c	c

Хариуцлагатай уул уурхайн кодекс

Бид Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциацийн “Хариуцлагатай уул уурхайн кодекс”-ын дагуу БОНЗ-ын ажлууддаа жил бүр өөрийн үнэлгээг хийж, гурван жил тутамд хөндлөнгийн баталгаажуулалт хийлгэдэг. Тус кодексийн хүрээнд 2025 оны үйл ажиллагаандаа өөрийн үнэлгээг хийж, 97%-ийн хэрэгжилттэй байгааг нээлттэй тайлагналаа. Энэ нь өмнөх оны үзүүлэлтээс 5.4%-иар өссөн үзүүлэлт юм. Энержи Ресурс ХХК нь 2019 онд “Хариуцлагаар Нэгд” аянд нэгдэн, харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурснаар уг

кодексийг хэрэгжүүлж эхэлсэн Монголын уул уурхайн салбарын анхдагч найман компанийн нэг болсон юм. “Хариуцлагатай уул уурхайн кодекс” нь хариуцлагатай уул уурхайн найман зарчимд тулгуурласан бөгөөд таван үндсэн чиглэл, 84 шалгуур үзүүлэлттэй. Энержи Ресурс ХХК нь 2025 оны үйл ажиллагааныхаа хүрээнд нийт 81 шалгуур үзүүлэлтийг амжилттай хэрэгжүүлж, дараах байдлаар үнэлэгдсэн байна:

17/17

Компанийн сайн засаглал
ба ил тод байдал

19/19

Хөдөлмөрийн харилцаа
ба хүний эрх

13/13

Хөдөлмөрийн эрүүл
мэнд ба аюулгүй байдал

18/18

Байгаль орчны
хамгаалал

14/17

Орон нутгийн хөгжил ба
олон нийтийн оролцоо



Хүлэмжийн хийн тооцооллын баталгаажуулалт

Бид 2017 оноос хойш хүлэмжийн хийн ялгарлаа тооцон тайлагнаж буй, Монголын анхдагч компаниудын нэг юм. 2023 онд хүлэмжийн хийн тооцооллын аргачлалаа шинэчилж, Сингапурын SGS компанитай гэрээ байгуулан нэг жилийн хугацаан дахь хүлэмжийн хийн тооцооллыг баталгаажуулах аудит хийлгэсэн. Цаашлаад 2025 онд уг үнэлгээг дахин амжилттай хийлгэж, сертификатаа хүлээн авлаа. Компаниас гаргасан хүлэмжийн хийн тооцоолол нь олон улсын ISO 14064-3:2019 стандартын дагуу, WRI/ WBCSD Greenhouse Gas (GHG) Protocol-ын шаардлагуудыг хангаж буйг уг үнэлгээгээр баталгаажуулаад байна. Улмаар уг үр дүнд нь үндэслэн хүлэмжийн хийг бууруулах хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж байна



CDP

Carbon Disclosure Project буюу CDP нь хөрөнгө оруулагчид, улс орон, бүс нутгаас аваад аж ахуйн нэгжүүдийн түвшинд байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг удирдахад зориулсан, ил тод мэдээллийн системийг удирддаг ашгийн бус байгууллага юм. Жил ирэх тусам CDP нь байгууллагуудын байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг хэмжиж, ил тод болгох, түүнийг түгээхэд дэмжлэг өгөх гол механизм болсон байна. Манай компани CDP-д сайн дурын үндсэн дээр нэгдсэн Монголын анхны компани бөгөөд 2025 онд уур амьсгалын өөрчлөлт дээр “С” үнэлгээ, усны аюулгүй байдал дээр “В” үнэлгээ тус тус авсан байна.



EITI

Манай компани 2009 онд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-д нэгдсэнээс хойш Засгийн газар, төрийн байгууллагууд ба олон нийтэд төлсөн татвар, хураамж, хандив тусламжийн мэдээллийг жил бүр ил тод тайлагнан мэдээлж байна. ОУИТБС нь нефть, байгалийн хий, ашигт малтмал олборлолтын салбарт ил тод, хариуцлагатай үйл ажиллагааг дэмжих дэлхий нийтийн стандарт юм. Ил тод байдал ба хариуцлагын зарчим нь олборлох үйлдвэрлэлийн салбарт засаглалыг сайжруулах, авилгийг бууруулах, орлогын шударга хуваарилалтыг хангах чухал хүчин зүйл юм.

3. Байгаль орчин

Энержи Ресурс компани нь байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх ажилд нэн тэргүүний ач холбогдол өгч, байгаль орчны чиглэлийн холбогдох бүхий л хууль, стандартуудыг мөрдөж, байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлдэг.

Манай компани нь 2018 оноос Монголын уул уурхайн салбарт анхлан ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо, ISO 14001:2015 Байгаль орчны менежментийн тогтолцоо болон ISO 45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна. Тус тогтолцооны хүрээнд бид жил бүр хөндлөнгийн аудитад хамрагдаж, үйл ажиллагааныхаа үр ашиг, чанар, байгаль орчны болон хөдөлмөрийн аюулгүй байдлын гүйцэтгэлийг тасралтгүй сайжруулсаар ирсэн. Мөн 2025 оноос ISO 46001:2019 Усны үр ашигтай хэрэглээний менежментийн тогтолцоог нэвтрүүлэн хэрэгжүүлж, усны нөөцийн зохистой хэрэглээ, хэмнэлттэй менежментийг үйл ажиллагаандаа хэвшүүлэн ажиллаж байна.

Манай компани нь үйл ажиллагаандаа байгаль орчны болон холбогдох салбарын хууль эрх зүйн шаардлагуудыг чанд мөрдөн ажилладаг. Үйл ажиллагааны хүрээнд Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Усны тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль болон Ашигт малтмалын тухай хууль зэрэг хууль тогтоомж, түүнтэй холбогдох төрийн бодлого, дүрэм журам, стандартыг мөрдөн хэрэгжүүлдэг.

Байгаль орчны менежмент төлөвлөгөөг жил бүр боловсруулан, төрийн захиргааны байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэн ажилладаг. 2025 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт нь 95.75%-тай хэрэгжсэн.

Нөхөн сэргээлт ба ногоон байгууламж

Нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа

Ухаа худаг уурхайн техник эдийн засгийн үндэслэлд тусгагдсан гадаад овоолгын техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, нөхөн сэргээлтийн ажлыг Монгол Улсын холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн, батлагдсан аргачлалын дагуу гүйцэтгэж байна. Уурхайн үйл ажиллагаа эхэлснээс хойш өнөөг хүртэлх хугацаанд хаягдал чулуулгийн гадаад овоолгын 82 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 12 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэсэн байна.

82 га

Талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн.

12 га

Талбайд биологийн нөхөн сэргээлт хийж ургамалжуулсан.

1,110 га

Ухаа худаг уурхайн хаягдал чулуулгийн овоолгын талбай

82 га

Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ 7%

2023 62 га

2024 72 га

2025 82 га

2025 онд Уурхайн хаягдлын овоолгын налуулж, хэлбэршүүлсэн талбайг шимт хөрсөөр хучих биологийн нөхөн сэргээлтийн эхний үе шатны ажлыг 10 га талбайд хийж гүйцэтгэсэн. Хаягдлын овоолгын хэлбэржүүлж шимт хөрсөөр хучсан 7 га талбайд мэргэжлийн байгууллагатай хамтран биологийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэсэн. 2023 онд батлагдсан Ухаа худаг

уурхайн ТЭЗҮ-ийн дагуу ордыг ашиглах хугацаанд байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн ажилд 184.9 тэрбум төгрөг зарцуулахаар тусгаж, үйл ажиллагааны үе шатуудыг төлөвлөсөн байдаг. Барууннаран уурхайн ТЭЗҮ-д ашиглалтын хугацаанд нийт 123.5 тэрбум төгрөгийг байгаль орчин, нөхөн сэргээлт хаалтын зардалд зарцуулахаар тусгасан.





2025 онд 126,600 ширхэг модыг дотоод нөөц болон ойн мэргэжлийн байгууллагуудтай хамтран тарьж, арчилж байна.

Мод үржүүлэг ба ойн зурвас

Ухаа худаг уурхайн олборлолтын үйл ажиллагаатай зэрэгцэн, ирээдүйд уурхайн биологийн нөхөн сэргээлтэд ашиглах нутгийн болон олон наст ургамал, мод, сөөгийг туршилтын байдлаар ургуулах, бүс нутагт зохицсон ургамлыг сонгож, тэдгээрийг үржүүлж бойжуулан биологийн нөхөн сэргээлт, ойн зурвас байгуулах, орчны тохижилтод ашиглах зорилгоор 2009 онд 2.5 га талбай бүхий мод үржүүлгийн талбайг байгуулсан. Мөн тус талбай дээр гоёл чимэглэл болон танин мэдэхүйн цэцэрлэгтэй бөгөөд нийт 22 төрөл зүйлийн мод таригдсан. 2025 онд мод үржүүлгийн талбайд говийн бүс нутагт тархан ургадаг жигд, сухай, хайлаас, тоорой, заг, харгана, бүйлс, хармаг, хотир зэрэг 35,000 мод болон нутгийн бутлаг ургамлыг үр болон мөчрөөр үржүүлж, 14,965 ширхэг тарьц суулгацыг орчны тохижилт, нөхөн сэргээлтэд зориулж үйлдвэрийн болон суурьшлын бүсэд тариалсан. Эдгээрт Монгол орны ховор, нэн ховор

статусаар бүртгэгдсэн элдэв навчит улиас буюу тоорой, Муркрофтын жигд Монгол бүйлс зэрэг модлог ургамлууд ч багтаж байна.

Мөн бид 2011 оноос хойш Говийн бүсэд цөлжилтийг бууруулах, хөрсний доройтлыг сааруулах зорилгоор Цогтцэций сумаас 7 км зайд ойн зурвас байгуулсан бөгөөд 10 гаруй жилийн хугацаанд 12,000 гаруй мод, сөөгтэй томоохон төгөл болсон байна.

Мөн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарьж ургуулах урт хугацааны төлөвлөлтийн дагуу говь цөлийн бүсэд хамгаалалтын ойн зурвас байгуулах замаар газар нутгийг хөрсний доройтол, цөлжилтөөс хамгаалах, ойжуулалтын ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, тус ажлыг шинжлэх ухааны зохих аргачлалд тулгуурлан ойн мэргэжлийн байгууллагатай хамтран 82,000 мод тарьж ургуулах ажлыг гүйцэтгэсэн, 87%-ийн амьдралтын хувьтай ургаж байна.

“Тэрбум мод” үндэсний хөтөлбөр

Энержи Ресурс ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжин ажиллахаа илэрхийлж 2030 он хүртэл 40 сая мод тарьж ургуулахаар нэгдсэн билээ. Уг хөдөлгөөний хүрээнд 40 сая мод тарьж, ургуулах урьдчилсан ТЭЗҮ-ийг “Монголын ойн салбарын мэргэжлийн холбоодын нэгдэл” ТББ-тай хамтран боловсруулж, төслийг хэрэгжүүлж эхэлсэн.

2025 оны тайлант жилд:

- Өвөрхангай аймгийн Хархорин суманд 40,000 мод
- Хэнтий аймгийн Хэрлэн суманд 50,000 мод
- Цогтцэций суманд 36,600 мод тус тус тарьсан бөгөөд нийтдээ 126,600 ширхэг модыг дотоод нөөц болон ойн мэргэжлийн байгууллагуудтай хамтран тарьж, арчилж байна.

Иргэдийн экологийн боловсролыг дэмжих, орчны тохижилт, ногоон байгууламжид, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Модтой хашаа” төслийг 2021 оноос хэрэгжүүлж байна. Энэхүү төсөл нь Цогтцэций сумын хашаатай өрх бүрийг 10 ширхэг модтой болгох, ногоон байгууламжтай болох хүсэл эрмэлзлийг дэмжих, сумын төвийн тоосжилтыг ногоон байгууламжийг нэмэгдүүлэх замаар бууруулах, Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулахад айл өрхийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой болно. Энэ төслийн хүрээнд 2021 оноос хойш 600 өрх айлд 7 зүйлийн 6,000 ширхэг модыг хүлээлгэн өгсөн. Мод үржүүлэх сонирхолтой 22 иргэн мод үржүүлгийн 3 цагийн практик сургалтад хамрагдаж, эдгээр иргэдээс 7 иргэн мод үржүүлэх ажлаа эхлүүлээд байна. Үүнээс 2025 оны байдлаар 121 айл өрхөд нийт 682 ширхэг мод, тарьц суулгацыг олгож, тарилт арчилгааны зөвлөмжөөр ханган ажилласан байна.

Байгаль орчны сайн дурын ажлын хөтөлбөр

Энержи Ресурс ХХК болон түнш байгууллагуудын хамтран хэрэгжүүлсэн Байгаль орчны сайн дурын ажлын хөтөлбөр нь 2025 онд ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх, байгаль орчны боловсролыг дээшлүүлэх, мөн ISO 14001 стандарт болон TSM протоколын хэрэгжилтийг дэмжих зорилготой хэрэгжсэн.

Тайлант хугацаанд хөтөлбөрийн хүрээнд биотехникийн ажил оролцох, мод үржүүлгийн үйл ажиллагаатай танилцах, уламжлалт болон орчин үеийн мод үржүүлэх арга барилд суралцах зэрэг ажлуудыг зохион байгуулсан. Эдгээр үйл ажиллагаанд Энержи Ресурс ХХК болон түнш байгууллагын сайн дурын дөрвөн оролцогч хамрагдсан бөгөөд байгууллага хоорондын хамтын ажиллагааг дэмжих, туршлага солилцох боломжийг бүрдүүлсэн.

Биологийн олон янз байдлын хамгаалал

Компани нь биологийн олон янз байдлыг хамгаалах чиглэлээр олон улсын “Mitigation Hierarchy” буюу нөлөөллийг бууруулах шаталсан аргачлалыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилладаг. Энэхүү аргачлалын хүрээнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах, доройтсон орчныг нөхөн сэргээх, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах зарчмыг баримталдаг. Үүний хүрээнд төслийн нөлөөллийн бүсэд амьтан, ургамлын судалгааг тогтмол хийлгэж, биологийн олон янз байдлын төлөв байдал, тархалт, амьдрах орчны өөрчлөлтийг үнэлэн хамгааллын арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлдэг. 2025 онд зэрлэг амьтдын амьдрах орчныг дэмжих биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлсэн нь “Minimize” буюу нөлөөллийг бууруулах шатанд хамаарч байгаа бол хууль бус ан агнуур, амьтны гаралтай эд эрхтэн, бүтээгдэхүүний хууль бус худалдаатай тэмцэх төсөл, хөтөлбөрүүдэд дэмжлэг үзүүлэн ажилласан нь биологийн олон янз байдлын хамгааллыг бэхжүүлэх “Avoid” буюу урьдчилан сэргийлэх арга хэмжээний нэг хэсэг юм. Түүнчлэн гар аргаар алт олборлолтын улмаас эвдрэлд орсон 2 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил хэрэгжүүлсэн нь “Restore/Rehabilitate” буюу нөхөн сэргээх үе шатанд хамаарах бөгөөд байгалийн тооройн бүлгэмдлийг хамгаалах, тархацыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн дүйцүүлэн хамгааллын ажлууд нь “Offset” буюу үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ юм.

Төслийн нөлөөллийн бүсийн амьтан, ургамлын судалгааны ажлын хүрээнд өнгөрсөн таван жилийн турш хийлгэсэн судалгааны үр дүнд хамгаалалтын ойн зурвас орчмоос долоон ангиллын бүлэгт хамаарах 54 зүйлийн нийт 1,600 гаруй шувуу бүртгэгдсэн байна. Жил бүрийн мониторингийн үр дүнгээс харахад шувууны зүйлийн баялаг болон тоо толгой тогтвортой есөх хандлага ажиглагдсан бөгөөд 2021 онд 18 зүйлд хамаарах 146 бодгаль, 2022 онд 22 зүйлд хамаарах 276 бодгаль, 2023 онд 34 зүйлд хамаарах 298 бодгаль, 2024 онд 29 зүйлд хамаарах 531 бодгаль, 2025 онд 28 зүйлд хамаарах ойролцоогоор 500 бодгаль шувуу тус тус бүртгэгдсэн байна. Эдгээр үзүүлэлтүүд нь нөхөн сэргээлт хийгдсэн талбайн экологийн нөхцөл сайжирч, шувууны амьдрах орчин улам бүр тохиромжтой болж байгааг харуулж байна.

2025 онд Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд, биологийн төрөл зүйлийг хамгаалах болон экосистемийн тэнцвэрт байдлыг дэмжих зорилгоор уулын туруутан болон бусад зэрлэг ан амьтдын идэш тэжээлийн хангамжийг сайжруулан биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэв. Үүнд:

- Өмнөговь аймгийн Говь Гурван Сайхан Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанд 600 кг ашигт долооцыг хандивлан өгч, өвөлжилтийн үеэрх идэш тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлэх, зэрлэг амьтдын тоо толгой, амьдрах орчны тогтвортой байдлыг хадгалахад бодит хувь нэмэр оруулсан.
- Мөн тус тусгай хамгаалалттай газар нутгийн Баяндалай сумын нутагт хамаарах хэсэгт ургамлын аймгийн суурь судалгаа, ховор ургамал болох хонин арцын тархалтын судалгааг хийлгэлээ.

Хууль бус ан, тэдгээрийн гаралтай эд, эрхтэн



бүтээгдэхүүний хууль бус худалдаатай тэмцэх төсөлд дэмжлэг үзүүлэх, идэвхтэн байгаль хамгаалагчийн үйл ажиллагааг дэмжих ажлын хүрээнд Цогтцэций сумын байгаль орчны мэргэжилтэн, байгаль хамгаалагчидтай хамтран идэвхтэн байгаль хамгаалагчдад “Өврийн дэвтэр”-ийн эх бэлтгэл, хэвлэлтийг хийн өгч, дэвтэр хөтлөх, өөрсдийн хариуцсан талбайдаа байгаль орчны хууль журмыг хэрэгжүүлэх талаар чиглүүлэх сургалт хийсэн. Мөн Цогтцэций сумын Хангинах, Тугийн цохио орчмыг хариуцсан идэвхтэн байгаль хамгаалагчийн үйл ажиллагааг дэмжиж дулаан өвлийн хувцас болон хиймэл дагуул дэмждэг гар утас, шаардлага хангасан дуран зэрэг зайлшгүй шаардлагатай хэрэгслээр хангалаа.

Баруун наран уурхайн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Ханхонгор сумын Мандах

багийн нутагт орших Гэр-Овоо нэртэй газар гар аргаар алт олборлосон 2 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэж, орон нутгийн ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн.

Иргэдийн оролцоот хяналт, мониторинг

Ухаа худаг уурхайн Байгаль орчны хэсэг болон Орон нутгийн харилцааны нэгж хамтран байгаль орчны хээрийн хэмжилтийн ажилд иргэдийг оролцуулж хэмжилтийн бодитой мэдээллийг иргэдэд олгох зорилгоор уг ажлыг жил бүр зохион байгуулдаг. 2025 онд нутгийн иргэдийг малчдын худгийн хэмжилт, уурхай болон сум орчмын агаарын чанарын хэмжилт хийх, танилцуулга мэдээлэл өгөх ажилд хамруулж, 4-р сарын 30-ны өдөр худаг ашиглагч 14 иргэний оролцоотойгоор зохион байгуулсан.

Байгалийн тооройн бүлгэмдлийг хамгаалах, устаж болзошгүй модлог ургамлын тархалтыг хадгалах зорилгоор Өмнөговь аймгийн Байгаль орчны газраас өгсөн чиглэлийн дагуу Номгон сумын байгаль хамгаалагчтай хамтран тус суманд орших “Гуагийн тоорой” хэмээх тооройн бүлгэмдлийг хашиж хамгаалах ажлыг гүйцэтгэсэн. Байгалийн унаган төрхийг хадгалах, тооройн ургалтын нөхцөлийг сайжруулах, залуу бодгалийн сэргэн ургалтыг нэмэгдүүлэх зорилгоор тоорой бүхий нийт 1.5га талбайг төмөр торон хашаагаар хашиж хамгаалсан. Энэхүү ажлын хэрэгжилт нь тухайн бүсийн тооройн ойн генетик нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрийг хадгалах чухал ач холбогдолтой юм.

Агаарын чанар ба тоосжилт

Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй тоосжилт, нүүрсний нарийн ширхэгт тоосонцор зэрэг агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Тоосжилтын хэмжилт ба сэргийлэх үйл ажиллагаа

2025 оны туршид нарийн ширхэгт тоосонцрын (PM2.5, PM10, TSP) хэмжилтийг Цогтцэций сум болон уурхай орчмын 9 цэгт DustTrak зөөврийн багажаар сар бүр 24 цагийн хугацаатайгаар хийж, уурхайн төв бүсэд Oizom Dustroid суурин автомат төхөөрөмжөөр 2025 оны 1 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн тасралтгүй хяналт тавин ажилласан. Сум болон уурхай орчмын хяналтын 9 цэгт нийт 108 удаагийн хэмжилт хийснээс 94 удаа буюу нийт хэмжилтийн 90 орчим хувь нь MNS 4585:2025 стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй, хэвийн үзүүлэлттэй гарсан.



OIZOM DUSTROID СУУРИН БАГАЖААР 2025 ОНЫ ТУРШ 339 ХОНОГИЙН ХЭМЖИЛТ ХИЙСЭН БӨГӨӨД 24 ЦАГИЙН ДУНДАЖ АГУУЛАМЖААР АВЧ ҮЗЭХЭД:

- PM2.5 тоосонцор 322 хоногт
- PM10 тоосонцор 243 хоногт
- Нийт тоосонцор 231 хоногт MNS4585:2025 стандартын зөвшөөрөгдөх хэмжээнд бүртгэгдсэн байна.

Тоосжилтыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлууд

- Нүүрс баяжуулах үйлдвэрийн хаягдлын далангаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор 3 га талбайд хучилтын ажил хийсэн.
- Цагаан хадны нүүрс ачиж буулгах талбайн сайжруулсан замаас төв зам руу нийлэх уулзварыг 15x40м хэмжээгээр өргөтгөн зохион байгуулж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилтыг бууруулсан.
- Цахилгаан станцын дэгдэмхий үнснээс үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор станц дээр Pugmill төхөөрөмжийг суурилуулж, үнсийг чийгшүүлэн багсарсан хэлбэрээр аюулгүй тээвэрлэн зайлуулах нөхцөлийг бүрдүүлсэн.
- Ухаа худаг уурхайн үйлдвэрлэлийн бүсийн хөнгөн тэрэг зорчих авто замд материалын шинэчлэл хийж, сайжруулсан шороон зам болгон шинэчилснээр замын хөдөлгөөнөөс үүсэх тоосжилтыг бууруулсан.



Агаарын чанар

Гадаад орчны агаарын чанарын шинжилгээний хүрээнд азотын исэл (NOx), хүхрийн исэл (SOx), нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)-ийн хэмжилтийг нийт зургаан цэгт итгэмжлэгдсэн лабораториор хийлгэсэн бөгөөд тайлант хугацаанд дээрх үзүүлэлтүүд MNS 4585:2025 стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй байна.

Бохирдуулагч хийн ялгаруулалт (тонн)	2023	2024	2025
NOx (Азотын исэл)	2,445	2,725	3,107
SOx (Хүхрийн исэл)	1.4	1.55	1.39
PM (Нарийн ширхэглэгт тоосонцор)	69.2	77.22	88.0

Хог хаягдлын менежмент

Хог хаягдлын үр дүнтэй менежмент нь манай байгаль орчны тогтвортой хөгжлийн бодлого, үүрэг амлалтын чухал бүрэлдэхүүн хэсэг юм.

Бид хог хаягдлыг системтэйгээр бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулах 3R зарчмыг компанийн хэмжээнд хэрэгжүүлдэг бөгөөд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгаж, байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглахыг зорин ажилладаг.

Хог хаягдлыг эх үүсвэр дээр бууруулах зорилгоор уурхайн хэсэг нэгжүүдийн үйл ажиллагааны онцлогоос хамааран энгийн ба аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь дэд төрлүүдэд ангилан ялгадаг. Түүнчлэн жил бүр ангилан ялгах хог хаягдлын нэр төрлийг нэмэгдүүлж, ангилан ялгалтыг сайжруулахад анхаарч ажиллаж байна. Мөн дахин ашиглах боломжтой хог хаягдал нь нийт энгийн хог хаягдлын 9.28%-ийг бүрдүүлсэн бөгөөд нийт 895 тонн хаягдлыг бүрэн дахин ашигласан байна. Мод, метал зэрэг дахин

ашиглах боломжтой түүхий эдийн боловсруулалт, ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор уурхайн үйл ажиллагаанаас үүссэн 91 тонн модон хаягдлыг цуглуулж, орон нутгийн иргэдийн ахуйн хэрэглээнд зориулан олгосон. Мөн 804 тонн төмрийн хаягдлыг тусгай зөвшөөрөл бүхий орон нутгийн компанид албан ёсоор хүлээлгэн өгч, зарим хэсгийг иргэдэд ахуйн зориулалтаар өгсөн байна. Тайлант хугацаанд нийт 22.41 тонн хуванцар савыг хуванцар дахин боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТМЛ Пластик ХХК-д нийлүүлсэн.

Бид зөвхөн уурхайн үйл ажиллагааны хүрээнд хогны менежмент хийгээд зогсохгүй сум орон нутгийн засаг захиргаа, сургууль, иргэд олон нийттэй хамтран ажиллах хүрээнд сургалт, арга хэмжээ зохион байгуулах, бүх нийтийн цэвэрлэгээнд үндсэн болон гэрээт компаниас хүн хүчний оролцоог хангах зэргээр ажиллаж байна.

Хог хаягдлын устгал	2023	2024	2025
Энгийн хог хаягдал (м³)	37,397	41,704	33,878 (9,647 тонн)
Хогийн цэгт хүргэсэн	97.3%	94.7%	96.1%
Дахин боловсруулсан	0.4%	1.1%	0.5%
Шатаасан	0.0%	0.5%	0.4%
Хадгалсан	2.4%	3.7%	3.0%
Эрчим (мЗ /ROMt)	0.0026	0.0025	0.00005



**2025 ОНД НИЙТ 9,647 ТОНН ЭНГИЙН ХОГ ХАЯГДАЛ
ҮҮСЭНЭЭС 2,169 ТОНН (22.48%) НЬ ДАХИН
БОЛОВСРУУЛАХ БОЛОМЖТОЙ ХОГ ХАЯГДАЛ БАЙСАН БА
ҮҮНЭЭС 688 ТОНН БУЮУ НИЙТ ХОГ ХАЯГДЛЫН 7.13%-ИЙГ
АМЖИЛТТАЙ ДАХИН БОЛОВСРУУЛСАН БАЙНА.**

Аюултай хог хаягдал

2025 онд нийт 4,617.1м³ (400.7 тонн) аюултай хог хаягдал үүссэн нь нийт хог хаягдлын 12%-ийг эзэлж байна. Үүнээс 88.8 тонн буюу нийт аюултай хог хаягдлын 33.6%-ийг тусгай зөвшөөрөлтэй нийлүүлэгчдэд шилжүүлж, зохих журмын дагуу боловсруулалт, устгалд оруулаад байна.


Аюултай хог хаягдлыг хүлээн авч устгал, дахин боловсруулалт хийдэг эрх бүхий компаниудтай гэрээний хүрээнд хамтран ажиллаж хуулийн шаардлагын хүрээнд химийн бодисын сав баглаа боодол, хаягдал тос, электрон хаягдал, принтерийн хор, өдрийн гэрэл гэх мэт хаягдлыг шилжүүлэн ажиллаж байна.

Тухайлбал аюултай хог хаягдлаас хаягдал тос 638 тонн, тосны филтер 220.5 м³, бочка 932 ширхэг, хаягдал өдрийн гэрэл 3.1 м³, тостой материал 2589.5 м³ гэх мэт тоо хэмжээгээр эх үүсвэр дээр

ангиан ялгагдсан байна. Ангиан ялгасан хаягдлыг зохих хууль, журмын шаардлагын хүрээнд эрх бүхий байгууллагад нийлүүлэх, дахин боловсруулах үйлдвэрүүдэд хүргүүлэх, нийлүүлэгч талд буцаах болон эрх бүхий мэргэжлийн байгууллагад өгч устгуулах хэлбэрээр зохицуулалт хийсэн.

Тайлант онд хүнд даацын автомашины 14,336 ширхэг хаягдал дугуйг холбогдох аж ахуйн нэгжүүдэд хүлээлгэн өгсөн байна. Түүнчлэн хүнд машин механизмын засварын төвийн үйл ажиллагаанаас үүссэн 1 тонны савлагаатай тосны савыг гэрээнд заасны дагуу ханган нийлүүлэгч компанид буцаан нийлүүлдэг. 2025 онд 1,552 ширхэг 1 тонны тосны савыг нийлүүлэгч компаниудад буцаан ачуулсан байна. Мөн нүүрс баяжуулах үйлдвэрийн хөөсрүүлэгч урвалжийн сав 192 ширхгийг нийлүүлэгч компанид буцаасан байна.

Аюултай хог хаягдлын устгал	2023	2024	2025
Аюултай хог хаягдал (м ³)	3,253	2,670	4,617
Хогийн цэгт хүргэсэн	14.7%	9.5%	2.4%
Дахин боловсруулсан	15.1%	24.7%	33.6%
Шатаасан	63.8%	36.7%	56.3%
Хадгалсан	6.4%	29.1%	14.0%
Эрчим (м ³ /ROMt)	0.0002	0.00016	0.000315



Бидний 2024 онд эхлүүлсэн E-хог хаягдлыг эх үүсвэр дээр ангиан ялгах төслөөр 2025 онд нийт 62 м³ цахилгаан хэрэгслийн хаягдлыг эрх бүхий дахин боловсруулах үйлдвэрт хүргүүлсэн байна.

Хаягдлын далан

Нүүрс баяжуулах үйлдвэрийн хаягдлын далан дээр газар доорх ус ба гадаад орчны тоосны хяналт шинжилгээг сар бүр хийдэг. Хаягдлын далангаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор хучилтын ажлыг 2025 онд 3 га талбайд хийж гүйцэтгэсэн. Хаягдлын далангийн менежменттэй холбоотой TSF management plan болон TSF operation manual нэртэй хоёр баримт бичгийг удирдамж болгон ашигладаг. Цаашид компани нь Канадын уул уурхайн ассоциацийн TSM Хаягдлын сангийн менежментийн протоколын шаардлагад үйл ажиллагаагаа бүрэн нийцүүлэхийг зорин ажиллаж байна. Тайлант онд үйлдвэрийн шингэн

хаягдалтай холбоотой нэг асгаралт бүртгэгдсэн ба түүнийг дахин давуулахгүй байх тал дээр анхаарч, хариу шуурхай арга хэмжээ авсан ба ослын судалгааг хийж залруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн. Асгаралтаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сар тутам ажлын байрны үзлэг хийх, засвар үйлчилгээний хэсгүүдийн ажилчдад сэдэвчилсэн яриа хийх, шинэ ажилтны болон нийт ажилчдад зориулсан сургалтад асгаралтын тухай агуулгыг оруулах зэргээр ажиллалаа. Түүнчлэн засварын төвүүдэд асгаралт үүссэн тохиолдолд цэвэрлэх иж бүрдлүүдийг зохих шаардлагуудын дагуу байршуулдаг.

Усны менежмент

Энержи Ресурс ХХК нь үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэглээний ус хангамжийн ухаалаг, дэвшилтэт системийг Ухаа худаг уурхайн цогцолборт ашигладаг. Усны хэрэглээ, хэмнэлт, дахин ашиглалт, бохир усны менежментийн хүрээнд компанийн зүгээс Монгол Улсын Усны тухай хууль, MNS 4943:2015 үндэсний стандартыг мөрдөхөөс гадна Олон Улсын Санхүүгийн Корпорацийн санаачилга болох "Өмнийн говийн усны менежментийн Сайн дурын кодекс"-ын гишүүнээр элсэж, нэгдсэн бөгөөд усны хэмнэлт, дахин

ашиглалтын мэдээллээ сайн дураар тайлагнадаг. 2025 онд бид ISO 46001:2019 Усны үр ашигтай хэрэглээний менежментийн тогтолцооны шаардлагуудыг өөрсдийн нэгдсэн менежментийн тогтолцоонд нэгтгэн нэвтрүүлж, усны хэрэглээг тасралтгүй сайжруулах систем, бүтэцтэй аргачлалыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Энержи Ресурс компани ундны усыг цэнгэгжүүлж, Цогтцэций сумын хүн ам болон уурхайн ажиллагсдын хотхоныг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, ундны

цэвэршүүлсэн усаар хангаж ирсэн. Усны хэрэглээ, олборлосон ус, хэрэглэсэн ус, цэвэршүүлсэн бохир усны хэмжээг хянахын тулд бид бодит цагийн мэдээлэл цуглуулах нэгдсэн телеметрийн хяналтын системийг ашиглаж байна. Уурхайн цогцолборын гол усны эх үүсвэр болох Наймант, Наймдай хөндийн худагас 2025 онд нийт 2.2 сая м³ гүний ус олборлосон бөгөөд бид гүний ус олборлох худгуудын өнгөн хэсэг буюу эхний 70-80 м хүртэлх хэсгийг тусгаарлаж хамгаалалт үүсгэдэг.

Тайлант онд нийт ашигласан усны 65 орчим хувь буюу **1,385,678м³** усыг Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрээс татан авч, дахин ашигласан. Мөн **976,000м³** үерийн усыг зориулалтын цөөрөмд хуримтлуулж, уурхайн төрөл бүрийн хэрэгцээнд ашиглалаа.



Усны хэрэглээ	2023	2024	2025
Ашигласан усны хэмжээ (м3)	2,913,508	2,998,260	2,231,760
Хэмнэлт, үр ашгийг дээшлүүлснээр нийт хэмнэсэн/дахин боловсруулсан усны хэмжээ (м3)	1,145,400	748,355	1,385,678
Цуглуулсан үерийн усны хэмжээ (м3)	73,700	511,000	976,000
1 тонн нүүрс угаахад зарцуулах усны хэмжээ (л)	162	170	152
Ахуйн бохир ус (м3)	192,845	204,071	195,179

УСНЫ ДАХИН АШИГЛАЛТЫН ХУВЬ

2023 он

41%

2024 он

23%

2025 он

65%

Эрчим хүчний хэрэглээ ба хэмнэлт



ТАЙЛАНТ ХУГАЦААНД НҮҮРС
БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР
БОЛОН ХОЛБОГДОХ
ХЭСГҮҮДЭД ХЭРЭГЖҮҮЛСЭН
АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР
ДҮНД **106 МЯНГАН КВТ.
ЦАГ ЦАХИЛГААН ЭРЧИМ
ХҮЧ ХЭМНЭЖ**, 30.3 САЯ
ТӨГРӨГИЙН БОДИТ ХЭМНЭЛТ
БИЙ БОЛГОСОН.

Байгалийн нөөцийг үр ашигтай, хариуцлагатай ашиглах нь байгаль орчны тогтвортой байдалд нэн чухал ач холбогдолтой бөгөөд бид эрчим хүч, усны хэрэглээгээ багасгах чиглэлд өндөр ач холбогдол өгөн ажиллаж байна. Уурхайн Нүүрс баяжуулах үйлдвэр нь Ухаа худагийн түгээх сүлжээний цахилгаан эрчим хүчний нийт хэрэглээний

70 орчим хувийг эзэлдэг тул эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээнүүд нь тус үйлдвэр дээр төвлөрч хийгдэж байна. 2025 онд өмнөх жилүүдэд хэрэгжүүлсэн сайжруулалтын үр дүнд тулгуурлан эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх ажлуудыг Нүүрс баяжуулах үйлдвэрт шат дараатайгаар үргэлжлүүлэн хэрэгжүүлэв.

ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНҮҮД	Хэмнэсэн эрчим хүч (кВт.ц)
Нүүрс баяжуулах үйлдвэрийн хэрэглэж буй хуурмаг чадлыг бууруулах төхөөрөмжийг засварлаж ажиллагаанд оруулснаар сүлжээний болон трансформаторын алдагдлыг бууруулж бий болгосон хэмнэлт	45,000
Төлөвлөгөөт зогсолттой байгаа хэсэгт том чадлын трансформаторуудыг түр салгаж, эрчим хүчний алдагдлыг багасгаснаар бий болсон хэмнэлт	61,327
Үйлдвэрийн хэмжээнд бий болсон нийт хэмнэлт	106,327

Цахилгаан хэрэглээ (кВт.цаг)	2023	2024	2025
Нийт цахилгаан хэрэглээ	102,142,348	117,226,599	123,116,074
Шууд хэрэглээ	99,636,196	106,505,229	114,342,936
Шууд бус хэрэглээ	2,506,152	10,721,370	8,823,138
Хүчдэлийн эрчим (кВт.цаг/ROM тонн)	7.3	6.9	8.4

Уур амьсгалын өөрчлөлт ба хүлэмжийн хийн ялгарлын тооцоолол



Уур амьсгалын өөрчлөлт, нүүрс хүчлийн хийн ялгарлын эсрэг дэлхий нийтийн хүчин чармайлт эрчимжиж байгаа энэ үед уул уурхайн компаниуд эдгээр ялгаруулалтыг бууруулах төрөл бүрийн арга, технологи дээр шаргуу ажиллаж байна. Орчны агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл зэргийн агаарт агуулагдах хэмжээг бид агаарын чанарын үндэсний MNS 4585:2016 стандартын дагуу, мэргэжлийн компаниар Ухаа худаг дахь мониторингийн цэгүүд дээрээс сорьц авхуулж, шинжлүүлдэг.

Бид 2017 оноос эхлэн компанийн үйл ажиллагааны явцад үүсэж байгаа хүлэмжийн хийн ялгарлыг хянах зорилгоор хүлэмжийн хийн тооцооллыг хийж, нээлттэй тайлагнаж эхэлсэн. Анх Түвшин 1 ба Түвшин 2-ын хүрээнд тооцооллыг хийж байсан бол 2023 оноос Түвшин 3-ын хүрээнд нийт 9 үзүүлэлтээр нарийн тооцооллыг гарган тайлагнаж байна.

Уг ажлын хүрээнд хөдөлгөөнт тоног төхөөрөмж болон цахилгаан станц зэрэг олон эх үүсвэрүүдээс ялгарч буй хүлэмжийн хийн агуулгыг ISO14064-1:2018 болон WRI/WBCSD хүлэмжийн хийн стандартуудын дагуу тооцоолж, ISO 14064-3:2019 стандартаар баталгаажуулж байна.

2025 бид хөндлөнгийн байгууллага болох Сингапурын SGS компаниар хүлэмжийн хийн тооцооллыг баталгаажууллаа.

Мөн хүлэмжийн хийн ялгарлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээг тогтмол төлөвлөн хэрэгжүүлдэг бөгөөд цахилгаан станцаас ялгарах хүлэмжийн хийг бууруулах үүднээс утаа шүүгчийн бүрэн ажиллагааг хангах, горимын тохиргоог хийх, жил бүр ногоон байгууламжийг өргөтгөж мод тарих гэх мэт арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ	2023	2024	2025
Түвшин 1	1,168,554	1,458,066	1,397,109
Түвшин 2	16,816	22,255	19,587
Түвшин 3	29,544,648	41,978,027	28,585,005
Нийт үйлдвэрлэл (CO ₂ e тн)	30,730,019	43,458,348	30,001,702
Эрчим (CO ₂ e тн)	2.11 t CO ₂	2.11 t CO ₂	1.96 t CO₂
Эрчим (м3 /ROMt)	0.0002	0.00016	0.000315

4. Нийгэм

Энержи Ресурс ХХК нь үйл ажиллагаагаар дамжуулан ажиллагсад, орон нутгийн иргэд, ханган нийлүүлэгчид болон бусад оролцогч талуудтай тогтвортой, харилцан үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлж, Монгол Улсын нийгэм, эдийн засагт эерэг, бодитой нөлөө үзүүлэхийг зорьж ажилладаг. Хүний нөөцийн бодлогын хувьд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлын тухай хууль болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 60 гаруй хууль, журмыг мөрдөхөөс гадна, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын конвенцуудтай нийцүүлэн боловсруулсан бодлого, хамтын гэрээ хэлэлцээрүүдийг чанд сахин биелүүлдэг.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр бид ажиллагсдын аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж, "Чанар, байгаль орчин, ХАБЭА"-н нэгдсэн менежментийн тогтолцооны бодлого болон компанийн дотоод 15 журам, ХАБЭА-н 34 журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг. Ажилтнуудыг осол, эрсдэлгүй нөхцөлд ажиллах боломжийг бүрдүүлэх зорилгоор дотоод сургалт, хяналт, сайжруулалтын ажлуудыг тогтмол зохион байгуулдаг.

Нийлүүлэлтийн сүлжээний менежментийн хүрээнд компанийн бодлого, журмуудаар дамжуулан ханган нийлүүлэгчидтэй байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, нийгмийн хариуцлагын шаардлагыг хангасан, тогтвортой хамтын ажиллагааг хөгжүүлж байна. Орон нутгийн хөгжил, хамтын ажиллагааны чиглэлд Энержи Ресурс компани нь байгуулагдсан цагаасаа хойш "сайн хөрш"-ийн зарчим баримтлан, олон нийтийн оролцоог дэмжих, тэдний санал бодлыг үйл ажиллагаандаа тусгах зорилгоор хэлэлцүүлэг, нээлттэй өдөрлөг тогтмол зохион байгуулж ирсэн. Мөн орон нутагт үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллөө тооцож, эерэг нөлөөллийг дэмжих, сөрөг нөлөөллийг бууруулах үүднээс урт хугацааны төсөл, хөтөлбөрүүдийг тогтвортой хэрэгжүүлж байна.



Ажиллагсад

Компанийн зүгээс ажлын байрыг нээлттэй, хүртээмжтэй, ил тод, шударгаар зарлах хэлбэрээр хөдөлмөрийн зах зээл дээрээс хүний нөөцийн бүрдүүлэлт хийж байна. 2025 оны 12-р сарын эцсийн байдлаар тус компани нийт 2,905 үндсэн ажиллагсадтай ба түүний 35.9%-ийг орон нутгийн иргэд, тодруулбал Өмнөговь аймгийн Цогтцэций, Даланзадгад, Баян-Овоо, Ханхонгор сумын иргэд зонхилон бүрдүүлжээ. Түүнчлэн гол туслан гүйцэтгэгч компаниудын хамтаар, Ухаа худаг цогцолборын хүрээнд нийт 7,800 орчим хүнийг шууд ба шууд бус ажлын байраар хангаж байна.

Тайлант онд зайнаас ажиллах уян хатан бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн. Тухайлбал, 6-аас доош насны хүүхэдтэй эмэгтэй ажиллагсдыг долоо хоногийн ажлын дөрвөн өдөр оффисоос, нэг өдөр гэрээс ажиллуулах, оффисын нийт ажиллагсдын ажлын цагийг өглөө 08-10, орой 17-19 буюу уян хатан байлгах зэрэг зохицуулалтуудыг урт хугацаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.

2,905

Үндсэн ажилтан

35.9%

Орон нутгийн иргэд



Хангамж, урамшууллын бодлого

Ажил олгогчийн хувьд компани нь хүлээсэн үүргийнхээ дагуу ажиллагсад холбогдох дэмжлэгийг үзүүлэн ажилладаг. Үүний зэрэгцээ компанийн зүгээс ажиллагсад зориулсан олон төрлийн нэмэлт хангамж, урамшууллыг олгож байна. Үүнд ажиллагсдыг эрүүл мэндийн болон гэнэтийн ослын даатгалд хамруулах, тогтмол эрүүл мэндийн үзлэгт хамруулах, тогтвортой ажиллагсдыг орон нутагт байр орон сууцаар хангах зэрэг багтана.



“Цэций” хороололд
орон сууц эзэмшүүлэх



“Уурхайчин”
хорооллын
газар өмчлөх эрх



Өвлийн түлш
олголт



Тогтвортой ажилласны
урамшуулал



Жирэмсний эрт
үеийн амралт



Хүүхэдтэй болсны
урамшуулал



Олон улсын ба
дотоодын эрүүл
мэндийн даатгал



Хувь хүний гэнэтийн
ослын даатгал



Сургалт, ур
чадвар ахиулах
боломжууд



Спортын үйл
ажиллагаатай
холбоотой арга
хэмжээнүүд



Хүүхдийн
баярын бэлэг



Байгалийн гамшигт
өртсөн үеийн дэмжлэг



Ажилтны гэр бүлийн
гишүүнээ алдсан үед
олгох хандив



Буцалтгүй тусламжууд



Шинэ гэр бүлийн
урамшуулал



Банкны зээлийн
үйлчилгээ



Ажилтнуудыг орон нутагт ая тухтай амьдрах, суурьших нөхцөл бололцоогоор хангах зорилгын хүрээнд 300 айлын орон сууц барих төслийг эхлүүлсэн бөгөөд 2025 онд **“Цэций хороолол 2А”** төслийн эхний ээлжийн **150 айлын** орон сууц ашиглалтад орсон.

2025 онд

- 1,900** гаруй ажилтан эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан.
- 166** ажилтантай тогтвортой ажиллах гэрээ байгуулан “Цэций” орон сууцны хороололд оруулсан.
- 122** ажилтантай тогтвортой ажиллах гэрээ байгуулан “Уурхайчин” гэр хороололд суурьшуулсан.
- 36** Ажилтанд “Цэций” хороололд орон сууц эзэмших эрхийг шилжүүлсэн.
- 1,900** гаруй ажилтанд өвөлжилтийн хэрэгцээнд нь зориулж тус бүр 5 тонн нүүрс олгосон.
- 100%** Бүх ажилтнууд эрүүл мэндийн болон гэнэтийн ослын даатгалд хамрагдсан.
- 180** орчим ажилтанд хүүхэдтэй болсны урамшуулал олгосон.
- 195** эрэгтэй, 22 эмэгтэй ажилтан эцэг эхийн чөлөө биеэр эдэлсэн.
- 100** гаруй ажилтанд буцалтгүй тусламж олгосон.
- 155** тэтгэвэрт гарсан ажилтнуудад ахмадын бэлэг олгосон.
- 4,000** гаруй хүүхдэд Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр бэлэг өгсөн.

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	2023	2024	2025
Нийт үндсэн ажиллагсдын тоо	2,372	2,545	2,905
Эмэгтэй ажиллагсдын эзлэх хувь	13%	13.4%	14.1%
Цалин урамшууллын зардал	146 тэрбум	190.4 тэрбум	244 тэрбум
Шинээр бий болгосон ажлын байр	1,108	905	1,142
Орон нутгийн ажиллагсад	35%	37%	35.9%
Орон нутгийн иргэдээс ажилд авсан удирдах түвшний ажилчдын хувь	24%	20.6%	30.3%
Хөгжлийн бэрхшээлтэй ажиллагсад	1%	1.1%	1%
30 хүртэлх насны ажиллагсад	32%	32.3%	33.4%
30-50 хүртэлх насны ажиллагсад	62%	59.2%	59.5%
50-аас дээш насны ажиллагсад	7%	8.5%	7.1%

Хэдийгээр хөдөө орон нутагт чадварлаг, мэргэжлийн боловсон хүчний нөөц дутмаг байдаг ч Энержи Ресурс компанийн ажиллагсдын шилжилт хөдөлгөөн харьцангуй тогтвортой хэвээр байна. Үүний үр дүнд үндсэн ажиллагсдын компанид ажилласан дундаж хугацаа нэмэгдэж байна. Энэ нь компанийн зүгээс ажиллагсдын нийгмийн асуудалд анхаарч, хөнгөлөлт, хангамжийн бодлогыг тууштай хэрэгжүүлэн, гэр бүлийн хамт орон нутагт шилжин суурьших урт хугацааны хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлсний үр дүн юм.



Тэгш боломж

Энержи Ресурс компани нь хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлэгчийн хувьд ажиллагсдынхаа эрхийг нэн тэргүүнд дээдэлж, бүх ажиллагсдыг ижил тэгш боломжоор хангахыг зорьдог. Компанийн хөдөлмөрийн дотоод журмын дагуу ажилтны нас, хүйс, шашин шүтлэг, улс төрийн үзэл баримтлал, оршин суугаа орон нутаг, харьяалал зэргээс үл хамаарсан цалин хөлс олгож, тэгш хөгжих боломжийг хангадаг бөгөөд цалингийн зөрүү нь зөвхөн тухайн ажилтны боловсрол, ур чадварын түвшин болон туршлага зэргээс хамаардаг.

Ажлын байр тэгш боломж (2025 он)

Үндсэн ажиллагсад: Нийт 2,905 ажилтан

14.1% эмэгтэй 85.9% эрэгтэй

Удирдах зөвлөлийн гишүүд (2026 оны нэгдүгээр сарын байдлаар)

42.9% эмэгтэй 57.1% эрэгтэй

Гүйцэтгэх удирдлагын түвшинд:

33% эмэгтэй 67% эрэгтэй

Дунд болон анхан шатны түвшинд:

14.1% эмэгтэй 85.9% эрэгтэй

Албан тушаал дэвшсэн байдал: 2025 онд дэвшсэн 254 ажилтнаас

15% эмэгтэй 85% эрэгтэй

Цалин, урамшуулал: Эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа 1:1 бөгөөд хүйсээс хамаарсан ялгаварлалгүй байна.



ТАЙЛАНТ ХУГАЦААНД ХҮЙСЭЭР БОЛОН ХУВЬ ХҮНД
СУУРИЛСАН ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТЫН АЛИВАА
ТОХИОЛДОЛ БҮРТГЭГДЭЭГҮЙ БАЙНА.

Ёс зүй, хүний эрх

Бид хүний эрхийн үндсэн зарчмуудыг байгууллагын соёлын салшгүй хэсэг болгон төлөвшүүлж, үйл ажиллагааныхаа хүрээнд орон нутгийн иргэд болон ажиллагсдын эрхийг хүндэтгэн, зөрчил үүсэхээс сэргийлэх зорилгоор хүний эрхийн эрсдэлийн үнэлгээ хийж, холбогдох хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал, Ухаа худаг уурхайн хүрээнд шинээр ажилд орсон ажилтнуудад Ёсзүйн код, Хөдөлмөрийн дотоод журам дахь хүний эрхтэй холбоотой заалтуудыг заавал танилцуулахаас гадна жил бүр бүх ажиллагсдыг хүний эрхийн сургалтад давтан хамруулдаг. Компанийн Ёсзүйн код нь ажлын байран дээрх ялгаварлан гадуурхалт, ашиг сонирхлын зөрчил, авлигал хээл хахууль зэрэг зүй зохисгүй үйлдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажиллагсдад удирдамж, зааварчилгаа болдог. Бид аливаа үйл ажиллагаа, байгууламжид насанд хүрээгүй хүүхдийг албадан хөдөлмөрлүүлэх эсвэл бүх хэлбэрийн албадан хөдөлмөрийг тэвчихгүй. Компани нь 2016 онд батлагдсан Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийг чанд мөрдөхөөс гадна 1990, 2002 онд соёрхон баталсан Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай конвенц, 2002 онд соёрхон баталсан Хөдөлмөрийн насны доод хэмжээг тогтоох тухай конвенц зэрэг холбогдох бусад баримт бичиг, хууль тогтоомжийг бүрэн мөрдөж ажилладаг. Бид ажлын байртай холбоотой бүхий л санал гомдол, маргааныг албан ёсоор бүртгэн авч, шалган, тогтоосон хугацаанд шийдвэрлэж, үр дүнг дээд удирдлагад шууд тайлагнадаг. Компанийн соёл, ажилтнуудын сэтгэл зүйн байдал болон итгэлцлийн түвшинг тогтмол үнэлж, гарсан үр дүнд үндэслэн зорилтот сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг. Ажилтнуудтай тогтмол ганцаарчилсан уулзалтуудыг зохион байгуулж, санал хүсэлт, хэрэгцээ, сэтгэл ханамжийг тодорхойлон, нээлттэй харилцааг хангаж байна. Цаашлаад алба, хэлтэс хоорондын ойлголцлыг сайжруулах зорилгоор “Хишиг өдөр” буюу ажилтнуудыг нэг өдрийн хугацаанд өөр алба, хэлтсийн ажил үүрэгтэй танилцан, гүйцэтгэх өдөрлөгийг жил бүр зохион байгуулж байна. Бид ажиллагсдын сайн дураараа эвлэлдэн нэгдэх, эрх ашгаа хамгаалуулахаар Үйлдвэрчний эвлэл байгуулах эрхийг хүндэтгэж ажиллаж ирсэн. Энержи Ресурс ХХК, Ухаа худаг салбар болон ажиллагсдын Үйлдвэрчний эвлэлийн хороо нь тайлант онд

шинэчилсэн хэлэлцээрүүдийг хийж, улмаар 2026-2028 онд мөрдөгдөх шинэ Хамтын гэрээг байгуулсан. Уг Хамтын гэрээний нөхцөлүүд нь ажилтнуудын хөдөлмөр эрхлэлтийн харилцаа, цалин хөлс, ажил амралтын хуваарь, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, ажилтнуудын эрх ашгийг хамгаалахад чиглэж байна.

Шүгэл үлээлт

Компанийн зүгээс Шүгэл үлээлтийн бодлогыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг. Ажилтнууд ба оролцогч талуудын зүгээс сэжигтэй буюу хууль бус, ашиг сонирхлын чанартай аливаа үйлдлийг мэдээлэх, санаа зовнилоо айдас түгшүүргүйгээр, нууцлалтай мэдээлэх боломж бүхий, хүртээмжит сувгуудыг бүрдүүлсэн бөгөөд мэдээлэгчийн хувийн нууцыг чанд хамгаалах баталгааг ханган ажилладаг. Ингэснээр “шүгэл үлээсэн” асуудлууд ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, Дотоод хяналтын хэлтэс болон Гүйцэтгэх удирдлагуудын түвшинд шийдэгдэх нөхцөлийг бүрдүүлсэн.



Сургалт хөгжил

Компанийн сургалт, хөгжлийн журмын дагуу ажилтнуудад үнэлгээ хийж, хувийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан, хэрэгцээнд нь нийцсэн сургалтад хамруулдаг. Энэхүү үйл явц нь ажилтнуудын мэргэжлийн болон ерөнхий ур чадварыг хөгжүүлж, байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд чиглэгддэг.

2025 онд нийт гадаад болон дотоод эх үүсвэртэй 3,115 удаагийн 214,157 цагийн сургалтад давхардсан тоогоор 30,011 ажилтан хамрагдсан байна. Нэг ажилтанд ногдох дундаж сургалтын цаг 7.1 цаг байлаа.

- Компанийн үндсэн аюулгүй байдлын ажилчид /ХАБ, Онцгой, БОХАБЭА/ 2025 онд нийт 1,252 цагийн сургалтад хамрагдсан. Уурхайн үйлдвэрлэлийн бүсэд нэвтрэх ажилтан бүр аюулгүй ажиллагааны зааварт хамрагдсан байх шаардлагын хүрээнд гэрээт компанийн ажилтнууд мөн аюулгүй ажиллагааны сургалтад хамрагддаг.

Орон нутгийн иргэдийг мэргэшүүлэн сургах

Компани байгуулагдсан цагаас эхлэн орон нутгийн, мэргэжилгүй иргэдийг уул уурхайн чиглэлээр мэргэшүүлж, ажлын байраар хангах, ажилтнуудынхаа мэргэжлийн ур чадварыг сайжруулах, хувь хүний ерөнхий ур чадварыг нэмэгдүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх сургалтуудыг тогтмол зохион байгуулсаар ирсэн.

Бид өнгөрсөн жилүүдэд орон нутгийн 1,800 гаруй залуусыг Ухаа худаг уурхайд Хүнд машин механизмын чиглэлээр мэргэшүүлэн сургаж, ажлын байраар хангасан байна.

2025 онд Хүнд машин механизмын операторын сургалтад нийт 198 хүн хамрагдан амжилттай төгссөн. Харин Хүнд машин механизмын засварчны сургалтад нийт 18 хүн амжилттай суралцан төгсжээ. Энэхүү сургалтын онцлог нь суралцагчид Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас олгодог чадамжийн гэрчилгээтэй болж, зөвхөн Монголдоо төдийгүй дэлхийн хаана ч ажиллах боломжтой болдог оршиж байна.

7.1 цаг

Нэг ажилтанд ногдох дундаж сургалтын цаг

214,157 цаг

Нийт сургалтын цаг

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

Аюулыг тодорхойлох ба урьдчилан сэргийлэх ажлууд 2025 онд

Энержи Ресурс компани нь эрхэм зорилго, үнэт зүйлсийнхээ хүрээнд ажилтнууддаа ээлтэй, эрүүл, аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, ажлаа аюул осолгүй гүйцэтгэх боломжийг ханган, ХАБЭА-н үйл ажиллагаанд онцгой анхаарал хандуулдаг. Энержи Ресурс ХХК-ийн Гүйцэтгэх Захирлын 2025 оны 12-р сарын 26-ны А/02 тоот тушаалаар Чанар, байгаль орчин ХАБЭА-н талаар баримтлах бодлого, компанийн чиглэлийг тодорхойлж, Нэгдсэн Менежментийн Тогтолцооны бодлогыг шинэчлэн баталсан.

Хөдөлмөрийн аюулгүй байдлын үзүүлэлтүүд

2025 ОНД 16.4 САЯ ХҮН/ЦАГ АЖИЛЛАСНААС ХУГАЦАА АЛДСАН **ГЭМТЛИЙН ДАВТАМЖ 0.86**, НИЙТ ГЭМТЛИЙН ДАВТАМЖ 2.51 БҮРТГЭГДСЭН НЬ СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН ХҮН/ЦАГТ ХАРЬЦУУЛСАН ДҮНДЖААС **20% БУУРСАН.**

Энэ онд нийт 323 аюултай тохиолдол буюу осол, осолд дөхсөн тохиолдлуудыг бүртгэн, судалж, залруулах арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлсэн.

Ослын тохиолдлуудаас гадна осолд дөхсөн тохиолдлуудыг судлан бүртгэж тохирох хяналт, залруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг. 2025 онд осолд дөхсөн 98 тохиолдлыг бүртгэн судалсан байна. Осолд дөхсөн тохиолдлыг судлан залруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх нь ослоос урьдчилан сэргийлэх үр дүнтэй менежмент юм.

7,379 эрсдлийг аюул мэдээлэх хуудсаар хүлээн авч

90.4% гүйцэтгэлтэйгээр шийдвэрлэсэн байна.

94% Эрсдэлийн удирдлагын журмын дагуу, ХАБЭА-н бодлого, зорилтуудад чиглэсэн үйл ажиллагаанд холбогдох 14 эрсдэл тодорхойлж, 24 хариу арга хэмжээ авахаар төлөвлөсөн ба гүйцэтгэл 94%-тай үнэлэгдсэн.

120 эрсдэлийн үнэлгээ хийж, 254 хяналтын арга хэмжээ төлөвлөснөөс

80% гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлсэн байна.

1,034 ХАБЭА-н гүйцэтгэлийг сайжруулах боломжууд буюу сайжруулалт хийгдсэн ажлын мэдээллийг бүртгэдэг. 2025 онд ХАБЭА-н чиглэлээр 1,034 сайжруулалт бүртгэгдсэн байна.

323 аюултай тохиолдлыг судлан бүртгэж, 941 хариу арга хэмжээг төлөвлөсөн ба

92.3% гүйцэтгэлтэйгээр шийдвэрлэсэн байна.

ХАБЭА-н сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэхийн тулд OHSE.ER.202. Ажлын байрны үзлэг хийх тухай журмыг мөрдлөг болгон ажилладаг. Байнгын болон түр хугацаагаар уурхайн болон үйлдвэрлэлийн бүсэд ажиллаж байгаа гэрээт компаниудын ХАБЭА-н үйл ажиллагааг хянахын тулд ажлын байрны үзлэгийг сар бүр тогтмол хийдэг.





ХАБЭА-н тасралтгүй сайжруулалт ба хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд

Бид ХАБЭА-н үйл ажиллагааг тасралтгүй сайжруулахыг зорьж, өнгөрсөн онд ослын судалгааны үр дүнд үндэслэн хэд хэдэн чухал арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

1. Хүнд даацын автомашины хучлага хучих, авах үед өндрөөс унах эрсдэлтэй холбоотой ослын залруулах арга хэмжээний хүрээнд хучлага бүтээх байгууламж дээр тооцоолол, туршилт зэрэг гурван ажлыг нэгтгэсэн цогц ажлын даалгаврыг боловсруулсан. Үүний үр дүнд 2025 онд уг төрлийн ослын тохиолдол шинээр бүртгэгдээгүй.
2. Advanced Driver Assistance Systems (ADAS), Driver Monitoring System (DMS) болон согтууруулах ундаа илрүүлэгч зэрэг жолоочид туслах системийг хүнд даацын тээврийн хэрэгслүүдэд үе шаттайгаар суурилуулж эхэлсэн. ADAS болон DMS нь тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагааг сайжруулж, жолоочийн нойрмоглол, ядралтаас үүдэх ослын эрсдэлийг бууруулах, замын нөхцөл байдал, саад бэрхшээл, аюулгүйн зай барилтыг хянах боломжийг бүрдүүлдэг ухаалаг хяналтын системүүд юм. Эдгээр системийг согтууруулах ундаа илрүүлэх хэрэгслүүдтэй хослуулснаар тээврийн үйл ажиллагааны гол эрсдлүүдийг бодит цагийн мэдээлэлд тулгуурлан хянах боломж бүрдэж байна.
3. 2025 онд компанийн хэмжээнд ажлын байрны аюулын мэдээллийг уламжлалт цаасан хэлбэрээс цахим системд шилжүүлснээр хүлээн авч, шийдвэрлэх шинэ аргачлалыг нэвтрүүлсэн. Энэ нь хөдөлмөрийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоонд бодит ахиц дэвшил авчирсан.
4. Нүүрс тээврийн замд хяналт шалгалтын лазер хэмжигчтэй хурдны төхөөрөмжийг нэвтрүүлэн ашиглаж эхэлсэн. Энэ нь тээврийн аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлд бодит ахиц гаргасан.
5. Өдөр тутмын хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ХАБ-ын ажилтнуудын ашигладаг жижиг оврын тээврийн хэрэгслүүдэд хяналтын камер суурилуулан ашиглаж эхэлсэн. Энэ нь хяналтын чанар, ил тод байдлыг сайжруулахад бодит ахиц дэвшил болсон.
6. Хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж, MNS 4990:2023 стандартын дагуу 90%-ийн итгэлцлийн түвшинг хангаж байна. Үүний үр дүнд хөдөлмөрийн нөхцөлийн эрсдэлийг 90%-ийн итгэлтэйгээр тодорхойлох боломж бүрдсэн.
7. Гал унтраах иж бүрэн системийг нэвтрүүлснээр барилга байгууламжийн галын аюулгүй байдлыг хангаж, хүний амь нас, эд хөрөнгийн хохиролд өртөх эрсдэлийг бууруулсан.

ХАБЭА-н сургалт

2025 онд нэг ажилтан дунджаар 56.3 цагийг ХАБЭА-н сургалтад зарцуулсан байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, зааварчилгааны журамд заасан агуулгын хүрээнд 2025 онд ХАБЭА-н 32 төрлийн сургалтад нийт ажилтнуудыг хамруулсан. Сургалтууд танхимаар зохион байгуулагдсан бөгөөд сургалт бүрийн дараа ур чадварыг баталгаажуулах шалгалт авч, үнэлгээ өгсөн.

56.3 цаг

1 ажилтны ХАБЭА-н сургалтад зарцуулсан дундаж хугацаа

32

ХАБЭА-н сургалтын төрөл



Ажилтнуудын эрүүл мэндийн үзлэг, үйлчилгээ

2025 оны хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэгт нийт 2,013 (Ухаа худагийн ажилчид 100%) ажилтан хамрагдсанаас эрэгтэй ажилтан 1,847 (92%), эмэгтэй ажилтан 166 (8%) тус тус байна. Төв оффисын ажилчдын хувьд хоёр жил тутам нэг удаа эрүүл мэндийн бүрэн үзлэгт хамрагдаж байна. MNS ISO/IEC 17020:2013 "Тохирлын үнэлгээ-хяналтын ажил эрхэлдэг төрөл бүрийн байгууллагын ажиллагаанд тавигдах шаардлага" стандартын дагуу итгэмжлэгдсэн эрх бүхий байгууллагаар жил бүр хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэж, улмаар үр дүнд нь суурилан Эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэг, шинжилгээний багцын маягтыг боловсруулж, батлуулдаг. Мөн нийт ажилчдад зориулсан сайн дурын эрүүл мэндийн хөтөлбөрүүд хэрэгжиж байна.

2,013

2025 онд хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан нийт ажилтнууд. Үүнээс:

1,847

92% нь эрэгтэй ажилтан

166

8% нь эмэгтэй ажилтан

Ажилчдын оролцоо

Ажилтнуудын оролцоо, зөвлөлдөөнийг хангах зорилгоор IMS.ER.08 Оролцоо, зөвлөлдөөн болон мэдээлэл, харилцаа зохицуулах журмыг мөрдлөг болгон ажилладаг. Энэхүү журмын дагуу үндсэн болон гэрээт компанийн ажилтнууд ХАБЭА-н зөвлөл, аюул мэдээлэх хурал, сэдэвчилсэн уулзалтууд, ослын судалгаа, комисс зэрэг үйл ажиллагаанд оролцож, зөвлөлдөх замаар ХАБЭА-н үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулдаг. 2025 онд бүх албаны төлөөлөл болон үйлдвэрчний эвлэлийн хорооны гишүүдээс бүрдсэн 16 гишүүнтэй зөвлөл байгуулагдаж, 3 удаагийн хурал зохион байгуулсан. Хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилт 91%-тай байна. Улирал бүр ХАБЭА-н манлайлагчдыг нийт ажилтнуудаас шалгаруулж, нийт 150 ажилтныг урамшуулсан. 2025 онд үндсэн болон гэрээт компанийн ажилтнуудын дунд 365 удаагийн сэдэвчилсэн уулзалтыг зохион байгуулсан байна.

	2023	2024	2025
Нийт ажилласан хүн/ цаг	12.6 сая	14.6 сая	16.4 сая
Эндэгдэл	3	1	3
Нийт гэмтлийн давтамж	2.55	1.85	2.51
Хөдөлмөрийн чадвар түр алдалтын давтамж	0.80	0.69	0.86
Мэргэжлээс шалтгаалах өвчлөл	0	0	0
Хууль, журамд нийцэж ажилласан байдал	93.4%	96%	98%
ХАБ-ын сургалт, зааварчилгаанд хамрагдсан ажилтны тоо (давхардсан тоогоор)	24,724	14,430	20,793

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа

Компани нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн үргэлжлүүлэх зорилгоор хууль, эрх зүйн шаардлагын дагуу жил бүр Гамшгаас хамгаалах төлөвлөгөө болон Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилладаг. Мөн компанийн хэмжээнд мөрдөгддөг холбогдох журмын хүрээнд галын дохиолол, гал унтраах систем болон дотор, гадна усан хангамжийн системд долоо хоног ба сар бүрийн тогтмол үзлэг шалгалт, тест туршилт, засвар үйлчилгээ хийж, системийн бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Гамшгийн үеийн зарлан мэдээлэх сургалтыг Монгол Улсын Засгийн газрын 339, 340 дүгээр тогтоолын дагуу, 3 дугаар сарын 4 дэх долоо хоногийн Пүрэв гарагийн 16 цагт зохион байгуулж, үндсэн болон гэрээт компанийн нийт ажилтнуудыг бүрэн хамруулан, газар хөдлөлтийн гамшгийн аюулын талаар танилцуулж, аврах бүлгийн ажилтнууд хүн нэг бүрийн аранзанд байх шаардлагатай зүйлсийг танилцуулсан бөгөөд энэхүү сургалт нь ажилтнуудыг гамшгийн үед түргэн шуурхай, зохион байгуулалттай ажиллах чадвартай болгоход чиглэгддэг.

Ханган нийлүүлэлтийн бодлого ба менежмент

2009 онд Ухаа худаг уурхайн үйл ажиллагаа эхэлснээс хойш өнөөг хүртэл бид дотоодын 2,500 орчим компанитай тогтвортой, тууштай хамтран ажиллаж ирлээ. Нүүрс болон аж үйлдвэрийн салбарт уурхайн олборлолт, өрөмдлөг, тэсэлгээ, нүүрс боловсруулалт зэрэг үндсэн үйл ажиллагаанаас гадна барилга угсралт, тоног төхөөрөмж, тос тосолгоо, түлш шатахуун, хувцас хэрэглэл, сэлбэг, байр, хүнс, цэвэрлэгээ үйлчилгээ зэрэг нийт 30-40 орчим салбар, дэд салбарын олон мянган ханган нийлүүлэгч аж ахуйн нэгжүүд оролцдог онцлогтой.

Компанийн хэмжээнд дараах бодлого, журмуудыг худалдан авалтын үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажилладаг бөгөөд эдгээрээр дамжуулан ханган нийлүүлэгчидтэй тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэлийг хангасан хамтын ажиллагааг бий болгон ажиллаж байна. Үүнд:

- Худалдан авалтын бодлого
- Тогтвортой хөгжлийн бодлого
- Худалдан авах ажиллагааны журам
- Хангамжийн гэрээний удирдлагын журам
- Гэрээт гүйцэтгэгч ханган нийлүүлэгчийн БОХАБЭА тогтолцоонд хяналт хийх, шаардлага тавих заавар

Тогтвортой буюу байгаль орчин, нийгэм, засаглалын шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчид

Компанийн хувьд бараа, ажил, үйлчилгээ үзүүлэх хүчин төгөлдөр мастер гэрээ бүхий 100 орчим ханган нийлүүлэгч уурхайн үйл ажиллагаанд туслан гүйцэтгэгч болон ханган нийлүүлэгчээр тогтвортой хамтарч, компанийн байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрэм журамд нийцүүлэн ажиллаж байна. Компанийн дотоод худалдан авалтын бодлого, журмын дагуу нэг удаагийн худалдан авалтуудыг хийхээс гадна Худалдан авалтын захиалгын батлагдсан хуудсанд үндэслэн шаардлагатай бараа, ажил, үйлчилгээг авдаг бөгөөд байгаль орчин, нийгмийн шалгуур, шаардлагуудыг тухай бүр тавин, хяналттайгаар ажиллаж байна.

17%

Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд байгаль орчин, нийгэм, засаглалын шалгуур үзүүлэлтээр сонгогдсон нийлүүлэгчдийн хувь



100%


₮2,6 их наяд
Нийт хийсэн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалт

77%

₮2 их наяд
Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалт

1%

₮15 тэрбум
Аймаг, орон нутгийн ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалт



2,500

Дотоодын компанитай тогтвортой, тууштай хамтран ажилладаг.

30-40

салбар, дэд салбарын олон мянган ханган нийлүүлэгч аж ахуйн нэгжүүд оролцон үйл ажиллагаа явуулдаг.

Оролцогч талуудын хамтын ажиллагаа



Бид Энержи Ресурс ХХК-ийн үйл ажиллагааны нөлөөлөл ба цар хүрээнд хамааралтай эсхүл шууд болон шууд бусаар оролцох боломжтой бүхий л оролцогч талуудын харилцааг үр дүнтэй зохицуулах, тэдний оролцоог ханган эргэх холбоотой хамтран ажиллах, харилцан итгэлцлийг бий болгох замаар урт хугацааны тогтвортой хөгжлийн суурь тавихыг зорьж ажилладаг. Мөн оролцогч, сонирхогч талуудтай харилцахдаа тэдгээрийн хэрэгцээнд нийцсэн, энгийн, хүртээмжтэй, орон нутгийн онцлог, уламжлал, зан заншил, соёлын байдлыг харгалзсан, олон талт хэлбэрээр харилцахыг эрхэмлэдэг.

Компанийн үйл ажиллагааны баримт бичгүүдэд боломжит бүхий л оролцогч, сонирхогч талуудын жагсаалтыг гаргасан байдаг. Бид 2025 онд Оролцогч сонирхогч талуудын бодлого, Оролцогч сонирхогч талуудын хэрэгцээг тодорхойлох, тэдгээрийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмыг тус тус шинэчлэн боловсруулж, орон нутгийн иргэд, олон нийтэд нээлттэй танилцуулсан.

Орон нутгийн иргэдийн идэвхтэй оролцоог хангах, хоёр талт идэвхтэй харилцаа үүсгэх, хамтран ажиллах дараах арга хэлбэрүүдийг ашигладаг. Үүнд:

- Шууд харилцаа (Орон нутгийн хөгжлийн хэсгээс нөлөөллийн бүсийн өрхүүд, иргэдийн гэрээр орох, биечлэн уулзах, сонсох, утсаар мэдээлэл авах, өгөх)
- Орон нутгийн мэдээллийн төвд иргэдийг биечлэн хүлээн авч, уулзах, дугуй ширээний ярилцлага хийх, санал хүсэлтийг нь сонсох
- Нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг хийх, төсөл хөтөлбөрүүдээ танилцуулах
- Орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагаа явуулах, иргэдийн олон талт төлөөллүүдийн оролцоог хангах
- Орон нутгийн сургалт, ажлын байрны нээлттэй өдөрлөг хийх
- Компанийн цахим харилцааны сувгуудаар харилцах, тайлан мэдээлэл тогтмол оруулах (сошиал сувгууд болон веб сайт)
- Зар мэдээ, тайлан, шинэ мэдээллийг сумдын соёлын төв, Засаг даргын тамгын газар, орон нутгийн мэдээллийн төв, уурхайчдын төв кемп зэрэг олон нийтийн газруудад байршуулах
- Хэсэгчилсэн санал асуулгууд авах, суурь судалгаа хийх
- Иргэдийн шууд оролцоог хангаж, байгаль орчин, худгийн усны ба тоосжилтын мониторинг хяналтанд оролцуулах
- Ухаа худаг наадам, орон нутгийн соёлын арга хэмжээ зохион байгуулах
- Өргөдөл гомдол, санал хүсэлтийг нээлттэй хүлээн авах систем
- Харилцааны бусад хэлбэрүүд багтана.

Оролцогч, сонирхогч талууд

1

Компанийн ажиллагсад, гэрээт, туслан гүйцэтгэгчид ба бэлтгэн нийлүүлэгчид

2

Өмнөговь аймгийн болон Цогтцэций сумын иргэд, малчид, шууд нөлөөллийн бүсийн айл өрхүүд

3

Нүүрс тээврийн маршрут дайран өнгөрдөг сумдын иргэд, малчид

4

Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагууд

5

Төрийн бус байгууллагууд, мэргэжлийн байгууллагууд ба сонирхлын бүлгүүд

6

Нүүрсний салбарт ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагууд

7

Хөрөнгө оруулагчид, банк, санхүүгийн байгууллагууд

8

Судалгаа, шинжилгээний, мэргэжлийн, хяналтын ба баталгаажуулалтын байгууллагууд

9

Бусад

Нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг

Энержи Ресурс компани нь уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө орон нутгийн иргэдэд нээлттэй хэлэлцүүлэг, мэдээлэл хийж, санал санаачилгыг нь үйл ажиллагаандаа тусгаж ирсэн анхдагч компаниудын нэг билээ. Уул уурхайн үйл ажиллагаа болон Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг олон нийтэд танилцуулах, мэдээлэл түгээх, санал авч үйл ажиллагаандаа тусгаж ажиллах зорилгоор 2008 оноос хойш нийт 10 удаагийн нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Тайлант онд “Ухаа худаг-20” жилийн ойн наадмын хүрээнд “Хариуцлагатай уул уурхайд иргэдийн оролцоо” сэдэвт нээлттэй өдөрлөгийг зохион байгуулсан. Тус өдөрлөгт орон нутгийн 600 гаруй иргэн идэвхтэй оролцож, компанийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй бодлого, төсөл, хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг шууд авч, санал бодлоо солилцов. Өдөрлөгийн үеэр 400 гаруй иргэн санал асуулгад хамрагдсан бөгөөд санал асуулгад оролцогчдын 90 орчим хувь нь өөрийн санал, хүсэлтийг бүрэн илэрхийлэх боломж хангагдсан гэж үнэлсэн байна. Түүнчлэн өдөрлөгийн тайлан, үр дүнг нэгтгэн олон нийтэд ил тод байршуулсан бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг дараах холбоосоор орж үзэх боломжтой. [Санал асуулгын үр дүн.](#)

Орон нутгийн зөвлөл

Орон нутгийн иргэдтэй нээлттэй харилцааг хөгжүүлж, шийдвэр гаргах явцад тэдний оролцоог хангах, дуу хоолойг тусгах үүднээс 2011 оноос хойш Ханбогд, Баян-Овоо, Цогтцэций сумдад 9-11 хүний бүрэлдэхүүнтэй орон нутгийн сайн дурын зөвлөлийг байгуулах санаачилгыг гаргаж, сумдын ИТХ-аар бүрэлдэхүүнийг батлуулан хамтран ажиллаж ирсэн. Тайлант онд Цогтцэций сумын орон нутгийн сайн дурын зөвлөл 11 гишүүнтэй ажилласан бөгөөд нийгмийн олон талт төлөөллийг багтаасан байдаг.

Өргөдөл гомдол шийдвэрлэх механизм

Компанийн зүгээс оролцогч бүхий л талууд, тэр дундаа орон нутгийн иргэдээс санал хүсэлт, өргөдөл гомдлыг боломжит бүхий л сувгаар нээлттэй хүлээн авч, шийдвэрлэхийг зорьж ажилладаг. Энержи Ресурс компанийн Өргөдөл гомдол хүлээн авах шийдвэрлэх, сонирхогч талуудын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох журмын дагуу өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хариу өгч, шаардлагатай тохиолдолд гомдлын нууцлалыг хадгалдаг. Энэ хүрээнд компанийн Орон нутгийн хөгжлийн албанд тайлант онд цаасаар **нийт 64 өргөдөл, хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн.**

Орон нутгийн “сайн хөрш”-ийн харилцаа үр дүнтэй хэрэгжихийн хэрээр компанид ирэх гомдлын тоо өнгөрсөн жилүүдэд маш цөөрч, зөвхөн санал, хүсэлт, өргөдөл ирэх нь олонтаа байна.

2025 ОНД ОРОН НУТГААС ИРСЭН САНАЛ, ХҮСЭЛТҮҮД

- *Иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих төслийн зээлд хамрагдах – 37*
- *Бохир ус нийлүүлэх-10*
- *Уурхайтай танилцах-5*
- *Эмчилгээний зардал-4*
- *Объект түрээслэх-2*
- *Айраг нийлүүлэх-2*
- *Худаг гаргуулах-1*
- *Тэмцээний зардал-1*
- *Хаягдал дугуй авах-1*
- *Усалгааны систем хоолой авах-1 тус тус багтжээ.*

Үүнээс гадна компанийн цахим сувгаар (сошиал медиа хаягууд болон албан мэйл хаягт) ирсэн хүсэлтүүдэд тухай бүр хариулж, эргэх холбоог ханган ажиллалаа.



Компани нь 2025 онд Өргөдөл, гомдол хүлээн авах механизмыг илүү боловсронгуй, шуурхай, хүртээмжтэй болгох үүднээс оролцогч, сонирхогч талууд буюу ажиллагсад, орон нутгийн иргэд, малчид, олон нийтээс ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг нээлттэй болон нууцлалтайгаар хүлээн авах, хөндлөнгийн оператор бүхий Битрикс CRM онлайн нэгдсэн системд шилжсэн.

Нийт системд бүртгэгдсэн идэвхтэй хандалтууд	6,003
<i>Мэдээлэл лавлагаа, тодруулга авсан хүсэлтүүд</i> (Анкет бүрдүүлэлт 864, Сургалт 557, Хүний нөөцтэй холбоотой 516, Холбогдох хүний мэдээлэл 375, Хаяг байршил 108, Төсөл хөтөлбөрүүд 45, Борлуулалт 14, Хандив тусламж 7, Бусад чиглэл 25)	2,511 (40%)
<i>Бусад санал, хүсэлтүүд</i> (Бүтээгдэхүүн үйлчилгээ санал болгосон 117, Хамтран ажиллах 134, Нээлттэй санал хүсэлт 68, Сургалт 48, Маркетинг сурталчилгаа 36, Хүний нөөц 33, Тээвэрлэлт түгээлт 13, Хандив тусламж 13, Уурхайтай танилцах, туршлага судлах 8, дотоод 20)	491 (10%)
<i>Албан мэйл хандалтаар ирсэн хүсэлтүүд</i> (Хамтран ажиллах хүсэлт, албан тоотууд)	537 (10%)
<i>Бусад хандалтууд</i> (сошиал чат, апп болон автомат хариултын хандалтууд)	2,464 (40%)



10

гаруй төрийн бус байгууллагатай
хамтарч ажиллаж, дэмжлэг үзүүлсэн.

₮77 тэрбум

нийгэм, олон нийтийн төлөөх төсөл,
хөтөлбөрүүдэд зарцуулсан.

Хандив, ивээн тэтгэлгийн хороо

Бид анх 2011 онд Тогтвортой хөгжлийн бодлого, 2012 онд Компанийн нийгмийн хариуцлагын бодлого, баримтлах зарчмуудыг батлан гаргасан бөгөөд эдгээрийг үйл ажиллагааныхаа бүхий л үе шатанд баримтлан ажиллаж ирсэн. Энэ хүрээнд нийгэм, орон нутагт чиглэсэн урт хугацааны төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээс гадна оролцогч талууд, орон нутгаас ирсэн санал хүсэлтүүдийг бүртгэлжүүлж, үйл ажиллагааны холбогдох чиглэлүүдэд дэмжин ажиллалаа. Компанийн менежментийн төлөөллүүд бүхий Хандив, тусламжийн хороо ажилладаг бөгөөд хандив, дэмжлэгийн хүсэлтүүдийг улирал тутам хэлэлцэж, шийдвэрлэдэг. Компанийн нийгмийн хариуцлагын бодлогын ерөнхий зарчмын хүрээнд

Хандив, тусламжийн хороо нь нэг удаагийн болон хувь хүний чанартай хандив, тусламжаас аль болох татгалзаж, өөрсдийн үйл ажиллагаа явуулдаг орон нутаг, түүнд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, эерэг нөлөөллийг дэмжих, урт хугацааны тогтвортой хөгжлийг бий болгох, нийгэм, олон нийт, олон хүнд үр өгөөжөө өгөх чиглэлүүдэд нэн тэргүүний ач холбогдол өгөхийг зорьдог. Дээрх зарчмын дагуу, Хандив, тусламжийн хороо нь ямар чиглэлд, ямар цар хүрээнд дэмжлэг үзүүлэх болон зарцуулах дэмжлэгийн хэмжээг тодорхойлж, мөнгөн ба мөнгөн бус, сайн дурын зэрэг олон хэлбэрээр зохих дэмжлэгүүдийг үзүүлж, мэдээллийг жил бүр тайлагнан ажиллаж байна.

Нийгмийн түншлэл

2025 онд нийгмийн сайн сайхны төлөөх ашгийн бус үйлсэд бодит хувь нэмрээ оруулах төсөл хөтөлбөрүүд болон ивээн тэтгэлгийн хүрээнд Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци ТББ, Энержи гурвын эсрэг гурав сагсан бөмбөгийн клуб ТББ, Сагсан бөмбөгийн аваргуудын дээд лиг ТББ, Цэцийн өнгө ТББ, Говийн уурхайчид ТББ, Монголын сагсан бөмбөгийн холбоо ТББ, Уул усны диваажин ТББ, Аз Итгэ Баяр ТББ, Эерэг хөгжил өсөх ирээдүй ТББ, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо ТББ гэх зэрэг нийгэм болон гишүүддээ үйлчилдэг 10 гаруй төрийн бус байгууллагатай хамтарч ажиллаж, дэмжлэг үзүүлсэн байна. Ингэснээр үйл ажиллагаа

явуулж буй орон нутгийн дэд бүтцийн хөгжил, олимпын төрлийн багийн спортын хөгжил, үндэсний бөхийн спорт, уул уурхай, аж үйлдвэрийн салбар болон залуусын хөгжлийг дэмжих зэрэг олон чиглэлийн төсөл, санаачилгууд болон урт хугацааны төсөл хөтөлбөрүүддээ мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр нийт 77 тэрбум орчим төгрөг зарцуулсан байна.

Сагсан бөмбөгийн спортын хөгжлийг дэмжигч

Монгол Улсад олимпын төрлийн спортыг дэмжих, багийн спортыг хөгжүүлэх зорилтын хүрээнд Энержи Ресурс компани нь сагсан бөмбөгийн үндэсний шигшээ багуудын албан ёсны түншээр зургаа дах жилдээ ажиллаж Энержи 3x3 сагсан бөмбөгийн клуб ТББ, Монголын сагсан бөмбөгийн холбоо ТББ, Сагсан бөмбөгийн аваргуудын дээд лиг зэрэг нийгмийн төлөөх, ашгийн бус ТББ-уудтай нягт хамтран ажиллаж ирлээ. Үүнд дотоодын болон Олон улсын сагсан бөмбөгийн холбооноос эрхтэй, Олимпын эрхийн тэмцээнүүдийг эх орондоо зохион байгуулах эрхийн лицензийн төлбөр, олон орны шилдэг тамирчдыг эх орондоо тав тухай байрлуулах зардал, монгол тамирчдын гадаад орнууд дахь тэмцээн уралдаанд оролцоход шаардлагатай төлбөр, хураамж, тамирчдын гадаад томилолт, бэлтгэл сургуулалт, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой гарч болох зардлуудад санхүүгийн дэмжлэг үзүүлж ирсэн. Хамтын ажиллагааны үр дүнд Монголд 3x3 төрлийн сагсан бөмбөгийн хөгжил жилээс жилд урагшлан, чансаа ахиж байгаа төдийгүй энэ төрлөөр Монголын шигшээ баг маань Олимпын тавцанд өрсөлдөж эхэлсэн билээ. Тайлант онд компанийн зүгээс Олон улсын сагсан бөмбөгийн холбооноос эрх авсан тэмцээнүүдийн хүрээнд Монголын тамирчдын гаргасан томоохон амжилтуудаас дурдвал, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо 2025 оны 6 дугаар сарын 23-29-ний өдрүүдэд “FIBA 3x3 World Cup-2025” 3x3 сагсан бөмбөгийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс Монгол Улсын 3x3 сагсан бөмбөгийн эмэгтэй шигшээ баг Дэлхийн аваргын мөнгөн медалийн эзэд болсноор Монголчууд багийн спортоор өндөр амжилт гаргах боломжтойг олон нийт, хүүхэд залууст таниулан сурталчилж чадлаа. Мөн уламжлалт сагсан бөмбөгийн төрлөөр тив, дэлхийд амжилтаа ахиулж, хүүхэд залуусын сагсан бөмбөг, багийн спортыг сонирхох сонирхол, оролцоо жилээс жилд нэмэгдэж байна.



“Улаанбаатар Амазонс” багийн тамирчин, Монголын 3x3 үндэсний шигшээ багийн гишүүн, Монгол Улсын Гавьяат тамирчин Б.АРИУНЦЭЦЭГ:

“Монгол Улсад 3x3 сагсан бөмбөгийн спорт сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж, олон улсын тавцанд нэр хүндтэй байр суурийг эзлэх болсон нь тохиолдлын зүйл биш юм. Энэ амжилтын цаана урт хугацаанд тууштай хэрэгжүүлсэн бодлого, тогтвортой санхүүжилт, мэргэжлийн удирдлага байж ирсэн. Ялангуяа Энержи Ресурс компанийн урт хугацааны, зорилтот дэмжлэг нь Монголын 3x3 сагсан бөмбөгийн хөгжлийн гол тулгуур болж чадсан. Өнөөдөр Улаанбаатар Амазонс баг болон Монгол Улсын эмэгтэй шигшээ баг дэлхийн шилдэг багуудтай эн тэнцүү өрсөлдөж, өрсөлдөж, FIBA 5x5 Women's Basketball League Asia 2025, FIBA 5x5 Asia Cup Division B, FIBA 3x3 Women's Series, FIBA 3x3 Asia Cup, FIBA 3x3 World Cup зэрэг олон улсын нэр хүндтэй тэмцээнүүдэд тогтмол амжилт үзүүлж

байна. Тэр дундаа 2025 оны Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс багаараа мөнгөн медаль хүртсэн нь Монголын сагсан бөмбөгийн түүхэнд онцгой бахархалтай хуудас болон бичигдсэн. Эх орондоо зохион байгуулагдсан тэмцээнд оролцож, Монгол түмнийхээ халуун дэмжлэг, уухайн дор тоглоно гэдэг тамирчин хүний хувьд юутай ч зүйрлэшгүй мэдрэмж байдаг. Тэр мөчид зөвхөн ялалт, амжилт бус, харин эх орныхоо нэрийг өндөрт өргөж яваагаа илүү гүн мэдэрдэг. Ийм амжилтын ард зөвхөн тамирчдын хичээл зүтгэлээс гадна системтэй бэлтгэл, зөв менежмент, тогтвортой санхүүжилт зайлшгүй хэрэгтэй. Энэ бүхнийг бүрдүүлж өгсөн Энержи Ресурс компанийн хувь нэмрийг үнэлж баршгүй юм. Миний хувьд сагсан бөмбөгийн спортоор 13 жил тууштай хичээллэж, өнөөдөр “Улаанбаатар Амазонс” баг болон Монгол Улсын шигшээ багийн бүрэлдэхүүнд багтан тоглож байна. Олон

улсын тавцанд “Монгол” гэсэн нэрийг энгэртээ зүүж, эх орноо төлөөлөн тоглох нь миний амьдралын хамгийн эрхэм, бахархалтай үүрэг билээ. Үүнээс гадна би зөвхөн өөрийн амжилтаар хязгаарлагдахыг хүсдэггүй. Ирээдүйн тамирчид болох дүү нартаа урам зориг өгч, тэдний зорилго мөрөөдөлд хүрэх замд нь гэрэл асаахыг зорьдог. Спорт бол зөвхөн тэмцээн, медаль биш харин хүмүүжил, тэсвэр хатуужил, эх оронч үзэл, хамтын үнэ цэнийг төлөвшүүлдэг хүчирхэг орчин юм. Тогтвортой дэмжлэгийн ачаар бид өнөөдөр зөвхөн ялалт байгуулаад зогсохгүй, ирээдүй үеийг бэлтгэж, Монголын нэрийг дэлхийд таниулж байна. Цаашид ч Энержи Ресурс компанийн дэмжлэг дор илүү олон амжилт гаргаж, илүү олон залуусын мөрөөдлийг бодит болгохын төлөө тууштай хөдөлмөрлөнө гэдэгт итгэдэг.”

Орон нутгийн хөгжил ба төсөл, хөтөлбөрүүд

Орон нутагтай хамтран ажиллах гэрээний хэрэгжилт

Ашигт малтмалын тухай хуулийн 42.1 дүгээр заалт болон Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор батлагдсан загвар гэрээний хүрээнд Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар болон Энержи Ресурс компани хооронд Хамтын ажиллагааны гэрээг 2017 онд байгуулсан.

Энэхүү гэрээний дагуу орон нутгийн онцлог, хөгжлийн бодлоготой уялдуулан олон нийтэд хүртээмжтэй, урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх зарчмыг баримталж, тайлант онд нийт 90 гаруй тэрбум төгрөгийг эдгээр ажлуудад зарцуулжээ.

/тэрбум төгрөг/

ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	2023	2024	2025
Орон нутгийн худалдан авалтыг дэмжих	14.1	15.7	15
Орон нутгийн дэд бүтцийг дэмжих	8.7	12.9	69.3
Орон нутгийн төсөл, хөтөлбөр, дэмжлэгүүд	5.7	5.2	7.2
Нийт	28.5	33.8	91.5

Эрчим хүчний нүүрсний дэмжлэг

2009 оноос хойш Өмнөговь аймгийн Даланзадгадын дулааны цахилгаан станц, Цогтцэций, Баян-Овоо, Булган, Хүрмэн, Мандал-Овоо, Манлай, Номгон, Ханбогд, Цогт-Овоо, Сэврэй, Ханхонгор сумдын эрчим хүч хэрэгцээний нүүрсийг үнэ төлбөргүй нийлүүлж, өвөлжилтийн бэлтгэлд хувь нэмрээ оруулж ирсэн.

2025 онд орон нутгийн засаг захиргаатай хийсэн арван гэрээний хүрээнд нийт 49,500 тонн баяжуулсан нүүрс, 8,400 тонн түүхий нүүрс тус тус олгож нийт 6.4 тэрбум орчим төгрөгийн үнэ бүхий эрчим хүчний нүүрсийг ОНӨААТҮГ-ууд, айл өрхүүдийн өвөлжилтийн хэрэгцээнд хандивласан байна.

- Өмнөговь аймгийн арван сумын хэрэгцээнд 40,500 тонн баяжуулсан болон түүхий эрчим хүчний нүүрс
- Дундговь аймгийн хэрэгцээнд 12,200 тонн баяжуулсан болон түүхий эрчим хүчний нүүрс
- Цогтцэций сумын айл өрхийн хэрэгцээнд 4,000 тонн баяжуулсан эрчим хүчний нүүрс
- Ханхонгор суманд 1,200 тонн баяжуулсан эрчим хүчний нүүрс тус тус олгогджээ.



Унд, ахуйн цэвэршүүлсэн усан хангамж

Бид ус хангамжийн системийнхээ хүрээнд уурхайн ахуйн болон үйлдвэрлэлийн усны хэрэгцээг хангахаас гадна Цогтцэций сумыг ундны цэвэршүүлсэн усаар хангадаг. Ингэхдээ говийн бүсийн эрдэсжилт, хатуулаг өндөртэй усыг 99% хүртэл цэвэршүүлэн шүүж, Монгол Улсын ундны усны стандартад хүргэн нийлүүлж байна. 2025 онд Цогтцэций сумын иргэдийн унд ахуйн хэрэгцээнд 188 мянган м3 цэвэршүүлсэн ундны усыг төвлөрсөн шугам сүлжээ болон зөөврөөр түгээсэн. Иргэд, оторчдын малын усалгаанд 0.8 мянган м3 ус түгээж, сумын иргэдийн хүнсний ногооны талбайн усалгаанд 24.2 мянган м3 усыг хөнгөлөлттэй болон үнэ төлбөргүй түгээсэн. Тайлант онд нийт цэвэр ус түгээлтэд ойролцоогоор 3 тэрбум төгрөг зарцуулсан байна. Цогтцэций сумын төв, Ажилчдын хотхон, "Цэций" хорооллыг ариутгах татуургын нэгдсэн системд холбосон бөгөөд сумын төвд орчин үеийн, европ стандартын, хоногт 1,200 тонн бохир ус хүлээж авч цэвэрлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламж ажиллаж байна. Уг байгууламж 2025 онд 132 мянган м3 ахуйн бохир усыг төвлөрсөн шугам сүлжээ болон зөөврөөр хүлээн авч цэвэрлэжээ.

188,000м³

2025 онд Цогтцэций сумын иргэдийн унд ахуйн хэрэгцээнд нийлүүлсэн цэвэршүүлсэн ундны усны хэмжээ

Ажиллагсдыг суурьшуулах хөтөлбөр

Сумын хүн амын шилжилт хөдөлгөөнийг тогтворжуулахад дэмжлэг үзүүлэх, ажилчдын тогтвор суурьшлыг дэмжих зорилгоор бид 2011-2013 онуудад "Уурхайчин" гэр хороолол, "Цэций" орон сууцны хорооллуудыг барьж байгуулсан. Тайлант онд шилжин суурьших ажиллагсдын хэрэгцээнд үндэслэн "Цэций хороолол 2А, 2Б" нийт 300 өрхийн орон сууцыг барьж эхний 150 айлын орон сууцыг ашиглалтад оруулсан. Мөн "Уурхайчин 1, 2" хорооллуудад өргөтгөл хийснээр 122 өрх тус хороололд нэмж суурьшсан байна.

2025 онд ажилтнуудыг эдгээр хорооллуудад суурьшуулах, тогтвортой ажиллах гэрээний хугацаа дууссан ажилтнуудад орон сууц болон гэр хорооллыг шилжүүлж өгөх ажлууд үргэлжлэн явагдлаа. 2025 оны эцсийн байдлаар "Цэций 1" хороололд 36 ажилтны орон сууцыг шилжүүлж гэрээний хэрэгжилтийг хангасан.

ИНГЭСНЭЭР АЖИЛЧДЫН
ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ
АМЬДРАЛЫН НӨХЦӨЛИЙГ
БҮРДҮҮЛЭХЭД
НИЙТ 2 ТЭРБУМ ОРЧИМ
ТӨГРӨГ ЗАРЦУУЛСАН
БАЙНА.

Орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, мэргэжил олгох

Бид ажлын байрны сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлах, орон нутгийн харьяат ажилчдыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд Хүний нөөцийн нээлттэй өдөрлөгийг тайлант хугацаанд Цогтцэций суманд дөрвөн удаа зохион байгуулсан.

2025 онд ажилд сонгон шалгаруулж авах тухай журмын дагуу нийт 1,142 ажилтан сонгон шалгаруулж авснаас 24% нь орон нутгийн иргэд байна. Мөн орон нутгийн иргэдийг мэргэшүүлэн сургаж, тогтвортой ажлын байраар хангах зорилгоор хүнд машин механизмын оператор бэлтгэх сургалтын төв ажиллуулж, ажилчдыг сургах, мэргэжил олгох сургалтуудыг зохион байгуулдаг. 2025 онд хүнд машин механизмын мэргэжил олгох арван удаагийн сургалтаар орон нутгийн 198 иргэнийг сургалтад хамруулж, 100% ажлын байраар хангасан ба үүнд эмэгтэйчүүд 30.3% хувийг эзэлж байна. Орон нутгийн ажилчдыг сургаж, хөгжүүлэхэд бид тайлант онд нийт 1 тэрбум орчим төгрөг зарцуулсан байна.

24%

2025 онд нийт сонгон шалгаруулж авсан ажилтнаас орон нутгийн иргэдийн эзлэх хувь

198

иргэнийг сургалтад хамруулж, 100% ажлын байраар хангасан.

₮1 тэрбум

Тайлант онд орон нутгийн ажилчдыг сургаж, хөгжүүлэхэд зарцуулсан мөнгөн дүн

Орон нутгийн жижиг бизнесийг дэмжих төсөл

Орон нутгийн малчид, иргэдийн жижиг, дунд бизнесийг дэмжих зорилгоор 2014 оноос бид Хас банктай хамтран “Малчдын тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөр”-ийг эхлүүлсэн нь 2017 оноос “Иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих төсөл” болгон өргөжсөн. Уг хөтөлбөрийн хүрээнд бид Хас банканд зээлийн сан байршуулж, хөнгөлөлттэй нөхцөлтэй, 3 хүртэлх жилийн хугацаатай, хүүгүй зээл олгож орон нутгийн жижиг бизнесүүдийн үйл ажиллагаанд бодит дэмжлэг үзүүлж байна.

Тайлант онд Цогтцэций сумын 14 иргэнд нийт 140 сая төгрөгийн хүүгүй зээлийг 3 хүртэлх жилийн хугацаатай олгосон ба зээлийн хугацаа хэтрэлт гараагүй байна. Зээл олгосон 14 иргэний бизнесийг үйл ажиллагааны төрлөөр ангилан харвал, хүнсний дэлгүүр, хүнсний ногоо тариалалт, үсчин, гоо сайхны үйлчилгээ, халуун ус, ээдол, бичиг хэргийн дэлгүүр, модон эдлэл, зөөврийн сууц, төрөл бүрийн худалдаа, хивс, угаалга цэвэрлэгээ зэрэг байна.

ЦОГТЦЭЦИЙ СУМЫН 14 ИРГЭНД
НИЙТ 140 САЯ ТӨГРӨГИЙН ХҮҮГҮЙ
ЗЭЭЛИЙГ 3 ХҮРТЭЛХ ЖИЛИЙН
ХУГАЦААТАЙ ОЛГОСОН.

₮1.1 тэрбум

Өнөөг хүртэл 130 гаруй жижиг бизнес эрхлэгчдэд 1.1 тэрбум төгрөгийн хүүгүй зээлийг олгож, бодит дэмжлэг үзүүлсэн байна.

Орон нутгийн жижиг бизнесийг дэмжих төслийн 2025 оны оролцогч С.Наранцэцэг:

“Би 2010 онд нөхрийнхөө хамт Цогтцэций суманд шилжин ирж суурьшсан. Анх таньж мэдэх хүнгүй шууд л шилжээд ирсэн ч өгөөжтэй сайхан нутаг биднийг хүлээж авсан. Манайх гэрээрээ жижиг бизнес эхлүүлэхээр төрөл бүрийн зүйл туршиж үздэг байлаа. Би өөрөө жимсэнд дуртай, мөн аливаа зүйлийг гоёмсог, үзэмжтэй байлгах сонирхолтой учраас жимсийг чамин савлаж борлуулдаг жимсний дэлгүүр ажиллуулах болсон. Дэлгүүрээ барьж, дотоод тохижилтыг цалингаараа бага багаар шийдэж явсан ч санхүүжилтийн хувьд хүндрэл тулгарсан. Тэр үед манай нөхөр Энержи Ресурс компаниас жижиг, дунд бизнесийг дэмжих зорилгоор хүүгүй зээл олгодгийг мэдээд өргөдлөө өгсөн. Зээлийн хүсэлт маань өргөдөл өгснөөс хойш сар орчмын дотор хурдан бүтсэн. Одоо орон нутгийн хүмүүс манай дэлгүүрийг сайн мэддэг болж, өргөнөөр үйлчлүүлж байна. Хүний хөл тасрахгүй байгаа нь ажиллахад их урам өгч байна.”



“Цалинтай оюутан - Амралтаараа ажиллая” зуны хөтөлбөр

Өмнөговь аймгийн оюутан залууст зориулан, зуны амралтаараа ажиллаж, нэмэлт орлого олох, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилготой “Цалинтай оюутан” зуны хөтөлбөрийг 2018 оноос хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөрт 2018, 2019, 2023, 2024, 2025 онуудад Ханхонгор, Цогтцэций, Баян-Овоо, Цогт-Овоо сумдын 150 орчим оюутан хамрагдаад байна. 2025 оны хувьд нийт 30 орчим оюутан уг хөтөлбөрт хамрагдлаа.

Өвс тэжээлийн тусламж

Орон нутагт дэмжлэг үзүүлэх “Сайн хөрш” хөтөлбөрийн хүрээнд бид 2008 оноос хойш жил бүр өвөл хаврыг өнтэй давахад зориулан орон нутгийн малчид, Өмнөговь аймгийн сумдын фондод өвс, тэжээлийн тусламж үзүүлж ирлээ. Жилд дунджаар 9-10 мянган боодол өвс, 45-50 тонн тэжээл татан авч бэлддэг. Тайлант онд Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын аюулгүйн фонд, байгаль орчны баг, Цогтцэций сумын 4 багийн 400 гаруй малчин өрх, Ухаа худаг уурхайн нөлөөллийн бүсийн 25 малчин өрх, Ханхонгор сумын Өвс тэжээлийн фонд, малчин өрхүүдэд өвс, тэжээлийн дэмжлэг үзүүллээ.

ЖИЛД ДУНДЖААР 9-10 МЯНГАН
БООДОЛ ӨВС, 45-50 ТОНН
ТЭЖЭЭЛ ТАТАН АВЧ БЭЛДДЭГ.

Орон нутгийн боловсролыг дэмжих хөтөлбөр

Бид Цогтцэций сумын дунд сургуулийн ачааллыг бууруулах, орон нутагт чанартай боловсрол эзэмших боломжийг бүрдүүлэх үүднээс “Мөрөөдөл” сургууль, цэцэрлэгийн цогцолборыг байгуулснаас гадна Орон нутгийн боловсролыг дэмжих хөтөлбөрийг урт хугацаанд хэрэгжүүлж байна. Тайлант онд бид уурхайчдын “Цэций” хороололд байгуулсан “Мөрөөдлийн хөтөч” сургалтын төвийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийж, сургалтын төвийн багш нарыг гэр бүлээрээ амьдрах орон сууцаар хангалаа. Мөн Цогтцэций сумын 1-р дунд сургуулийн үйл ажиллагаанд хүндрэл үүссэнтэй холбоотойгоор тус сургалтын төв болон “Цэций” хорооллын 2-р байранд сургуулийн сургалт, хичээлийн үйл ажиллагаа явуулах боломжоор ханган ажиллаж байна.



Эрүүл мэндийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр

Орон нутгийн эрүүл мэндийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд бид эмнэлгийн нарийн мэргэжлийн үзлэг, оношилгоог тогтмол зохион байгуулж ирсэн. Тайлант онд ЭХЭМҮТ-ийн эмч нарын “Хайрлая хуваалцъя” ТББ, Цогтцэций сумын сум дундын эмнэлэгтэй хамтран хүүхдийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг Цогтцэций суманд зохион байгуулсан. Хүүхдийн эрүүл мэндийн үзлэгт сумын 0-16 насны хүүхдүүдийг хамруулан, нийт 900 орчим хүүхдэд үнэ төлбөргүй үзлэг, оношилгоо хийгдсэн байна.

900 гаруй хүүхэд

үнэ төлбөргүй үзлэг, оношилгоонд хамрагдсан байна.

Газар тариалан эрхлэлтийг дэмжих төсөл

Цогтцэций сумын иргэдийн газар тариалан эрхлэх санаачилгыг дэмжих, газар тариалан эрхлэх туршлага, ур чадварыг нэмэгдүүлэх, нутгийн хөрсөнд ургуулсан эрүүл төмс, хүнсний ногоогоор өрхийн хэрэгцээгээ хангахад дэмжлэг үзүүлэх, цаашлаад өрхийн бизнесийг дэмжих зорилготой газар тариалангийн төслийг бид өөрсдийн байгуулсан Ойн зурваст 2011 оноос хойш хэрэгжүүлж байна. 2025 онд Ойн зурвасын 4 га талбайд Цогтцэций сумын 52 өрх, 1 байгууллага, 2 хоршоо 27 нэр төрлийн хүнсний ногоо тариалж нийт 15 тонн ургац хураан авлаа.



Мөн “Ургацын баяр-2025” шинэ ногооны үзэсгэлэн худалдааг 10-р сард “Цэций” хорооллын хөл бөмбөгийн талбайд зохион байгуулж, ногоо тариалсан 20 гаруй иргэд хүнсний ногоо, даршилж боловсруулсан бүтээгдэхүүнийхээ амталгаат худалдаагаар оролцсон байна.

Бэлчээрийн усан хангамж

Тайлант онд “Сөн дүүрэн” газар тариалангийн хоршооны ногоо усалгааны хэрэгцээнд зориулан нарны хавтан бүхий тоноглолтой гүний худаг гаргаж өгсөн. Мөн уст цэг, булаг шандын эхийг хамгаалах зорилгоор 2025 оны 9-р сард Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Сийрст багийн нутагт байрлах түүхт, соёлын дурсгалт газар “Сайн бичигтийн хийд”-ийн булгийг хашаажуулж, мал болон тээврийн хэрэгслийн нөлөөнөөс хамгаалах ажлууд хийлээ.

Ахмадууд ба зорилтот бүлгийн дэмжлэг

Сар шинийн баярыг тохиолдуулан жил бүр Өмнөговь аймгийн Ханхонгор, Цогтцэций, Баян-Овоо, Цогт-Овоо сумдын 70-аас дээш насны ахмад буурлуудад хүндэтгэл үзүүлдэг уламжлалтай. 2025 онд Цогтцэций, Ханхонгор, Баян-Овоо, Цогт-Овоо сумдын өндөр настай 450 орчим ахмадад хүндэтгэл үзүүлж, хүнсний багцаар дэмжлэг үзүүллээ. Цаашид хүнсний тусламжийн хүрээнд дэх зорилтот өрхүүдийн судалгааг орон нутгийн Хөдөлмөр, халамжийн албатай хамтран нарийвчлан гаргаж, тогтвортой амьжиргааг нь дэмжих чиглэлд тодорхой ажлууд хийхээр төлөвлөж байна.

Шагнал

2025 ОНД ЭНЕРЖИ РЕСУРС КОМПАНИ НЬ МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМРЭЭ УЛАМ БАТАТГАЖ, ӨМНӨХ ЖИЛИЙН АМЖИЛТУУДАА ҮРГЭЛЖЛҮҮЛСЭН ЖИЛ БАЙЛАА. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ 17 ЖИЛИЙН ТУРШИД МОНГОЛ УЛСЫН ТОП-100 АХУЙН НЭГЖ, ОНЫ ОНЦЛОХ 10 АЖ АХУЙН НЭГЖ, ШИЛДЭГ ТАТВАР ТӨЛӨГЧ АЖ АХУЙН НЭГЖ ШАЛГАРУУЛАЛТУУДЫН ЭХНИЙ БАЙРУУДАД ТОГТМОЛ ЭРЭМБЭЛЭГДЭЖ, БАЙР СУУРИА ХАДГАЛЖ ИРЛЭЭ.

ТОП-100 АЖ АХУЙН НЭГЖ

Монгол Улсын Засгийн газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим (МҮХАҮТ) хамтран нийгэм, эдийн засгийн хөгжилд өндөр хувь нэмэр оруулж буй "ТОП-100 аж ахуйн нэгж"-ийг эрэмбэлж, хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааг жил бүр зохион байгуулдаг уламжлалтай.

2010 он	IV байр
2011 он	III байр
2012 он	IV байр
2013 он	IV байр
2017 он	V байр
2018 он	V байр
2019 он	V байр
2020 он	V байр
2021 он	X байр
2022 он	III байр
2023 он	IV байр
2024 он	II байр
2025 он	II байр

ЭНТРЕПРЕНЁР - ОНЫ ОНЦЛОХ 10 АЖ АХУЙН НЭГЖ

Бизнесийн салбарт өндөр амжилт гаргаж, нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж буй онцлох аж ахуйн нэгж, байгууллага, бизнес эрхлэгчдийг МҮХАҮТ-аас жил бүр тодруулдаг.

2010 он	Гранпри шагнал
2011 он	IX байр
2012 он	VII байр
2013 он	VIII байр
2017 он	VI байр
2018 он	X байр
2019 он	Мөнгөн меркури
2020 он	Хүрэл меркури
2021 он	Мөнгөн меркури
2022 он	Мөнгөн меркури
2023 он	Мөнгөн меркури
2024 он	Мөнгөн меркури
2025 он	Мөнгөн меркури

ШИЛДЭГ ТАТВАР ТӨЛӨГЧ

Жил бүрийн 5-р сард Татвар төлөгчдийн өдрөөр Монгол Улсын Татварын Ерөнхий газраас шилдэг татвар төлөгч аж ахуйн нэгжүүдийг шалгаруулдаг. Сангийн яамнаас хамтран тодруулдаг уг шалгаруулалтад татварын нэгдсэн дүнгээс гадна татварын цаг хугацаандаа хийгдсэн төлөлт, хариуцлагатай, үлгэр жишээч байдлыг гол шалгуур болгон авч үздэг.

2010 он	V байр
2011 он	I байр
2012 он	V байр
2013 он	V байр
2017 он	VII байр
2018 он	VII байр
2019 он	V байр
2020 он	VII байр
2021 он	IV байр
2022 он	IV байр
2023 он	IV байр
2024 он	IV байр
2025 он	VI байр

5. Засаглал

Энержи Ресурс компани нь олон улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй, нээлттэй хувьцаат компанийн зарчмаар компанийн засаглалыг байгууллагын хөгжлийн чухал баримтлал гэж үздэг бөгөөд хувь нийлүүлэгчид ба бүхий л оролцогч талуудын эрх ашиг, адил тэгш харьцах зарчим болон мэдээллийн ил тод байдлыг хангахад онцгой анхаарч ирсэн. Бид компанийн сайн засаглалыг төлөвшүүлэх нь дэлхийн жишигт нийцсэн үйл ажиллагаа бүхий, тэргүүлэгч аж ахуйн нэгж байх гол хүчин зүйл гэж үздэг. Иймд дотоодын болон олон улсын хэмжээнд мөрдөгддөг, сайн засаглалын шаардлагуудыг биелүүлэн ажилладаг төдийгүй нээлттэй, ил тод, хариуцлагатай байдал, шийдвэр гаргалтын энгийн, түргэн шуурхай орчныг бүрдүүлж, бодлого, дүрэм, журмуудынхаа хэрэгжилтийг ханган ажилладаг.



Групп компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)


ГИШҮҮД

Тайланг нийтлэх үеийн байдлаар, групп компанийн ТУЗ нь долоон гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд гүйцэтгэх түвшний гишүүн хоёр, гүйцэтгэх бус гишүүн гурав, хараат бус гурван гишүүн тус тус багтана.

БҮТЭЦ

Компанийн үйл ажиллагааны тодорхой чиглэлүүдийг үр дүнтэй удирдан зохион байгуулах зорилгоор ТУЗ нь Аудитын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороо болон Байгаль орчин, нийгэм, засаглалын (БОНЗ) хороо гэсэн дөрвөн хороотойгоор ажиллаж байна.

ТУЗ-ийн Олон талт байдлын бодлого нь 2013 онд батлагдсан бөгөөд 2022 оны 10 дугаар сар болон 2025 оны 3 дугаар сард тус тус шинэчлэгдсэн. ТУЗ-ийн зүгээс олон талт бүрэлдэхүүний ач холбогдлыг бүрэн хүлээн зөвшөөрч, дэмждэг бөгөөд олон талт байдлыг нэмэгдүүлэх нь компанийн өрсөлдөх чадварыг хадгалах чухал хүчин зүйл гэж үздэг. 2025 онд ТУЗ-ийн гишүүдийн бүтцэд өөрчлөлт орж, хоёр шинэ гишүүнээр эгнээгээ сэлгэлээ.



Аудитын хороо

Группийн Аудитын хороо нь санхүүгийн тайлагналд хараат бус хяналт, үнэлгээ хийх, мөн эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоо болон дотоод аудитын үйл ажиллагааны үр нөлөөтэй байдлыг хянан үнэлэх замаар ТУЗ-ийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй хөндлөнгийн, хараат бус дөрвөн гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

Энержи Ресурс компанийн Төлөөлөн удирдах зөвлөл

Түүнчлэн Энержи Ресурс компанийн бие даасан ТУЗ шинээр байгуулагдаж, 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаа явуулж байна.



Авлигаас ангид байх зарчим

Энержи Ресурс компанийн Хөдөлмөрийн дотоод журам, Ёсзүйн дүрэм, Компанийн нийгмийн хариуцлагын бодлого болон хангамж, худалдан авалттай холбоотой бодлого, журмуудад авлига хээл хахуулаас ангид байж, шийдвэр гаргахад албан тушаалтанд нөлөөлөх, давуу байдал бий болгох, шан харамж олгохоос зайлсхийх, бүх төрлийн бизнесийн харилцаанд авлига, хээл хахууль авахыг хориглосон байдаг. Энэхүү шаардлага нь манай үндсэн болон туслан гүйцэтгэгч компаниудын ажиллагсдад мөн хамаарна. Бид бүхий л оролцогч талуудтайгаа нягт хамтран ажиллах замаар авлигын эсрэг хатуу зарчим барьж, нийгмийн хариуцлагатай, ханган нийлүүлэлтийн сайн туршлага хэрэгжүүлэхийг эрмэлздэг. Авлигын эсрэг бодлого, үйл ажиллагааг Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх журмаар зохицуулдаг бөгөөд уг журмын дагуу хөтөлбөр гарган нийт ажилтнуудад ашиг сонирхлоос ангид байх

талаар сургалт зохион байгуулдаг. 2025 онд нийт 2,200 гаруй ажилтан энэхүү сургалтад хамрагдаад байна. Цаашлаад Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх журмын хүрээнд бүх ажиллагсдын албан ёсны баримт бичгийг маягтаар баталгаажуулж бөглүүлэн тухай бүр архивладаг. Манай худалдан авалт болон холбогдох үйл ажиллагаа нь шударга бус бизнесийн хэлцэл, сэжигтэй төлбөр болон терроризм, мөнгө угаахтай холбоотой санхүүжилтийг эрс хориглодог. Бид Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Терроризмтой тэмцэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Монгол Улсын Эрүүгийн хууль зэрэг холбогдох хууль тогтоомжуудыг чанд даган мөрдсөөр ирсэн.

Тайлант онд манай үйл ажиллагаатай холбоотой авлига, хээл хахууль, ашиг сонирхлын буюу хууль бус үйлдлийн тохиолдол гараагүй байна.

Ил тод байдал

Бид олон улсын ISO 26000: Компанийн нийгмийн хариуцлагын зөвлөмж болон Олон Улсын Санхүүгийн Корпораци, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк зэрэг байгууллагуудаас гаргасан удирдамжуудад үндэслэн Тогтвортой хөгжлийн болон Компанийн нийгмийн хариуцлагын үндсэн зарчмуудыг тодорхойлж, 2011 оноос хойш баримтлан ажиллаж байна.

Түүнчлэн оролцогч, сонирхогч талуудын итгэлийг хүлээх үүднээс үйл ажиллагаагаа олон нийт, хөрөнгө оруулагчид, төр засаг, оролцогч талууд, олон улсын банк санхүүгийн байгууллагуудад нээлттэй тайлагнаж ирсэн. 2009 онд үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш ОУИТБС-д нэгдэн, төр засгийн байгууллагад төлсөн төлбөр, татвар хураамжаа жил бүр сайн дураараа, нээлттэй тайлагнаж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх үйлсэд нэгдэн ажиллаж байна.

Мөн Монголын уул уурхайн үндэсний ассоциаци, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам хамтран санаачилсан “Хариуцлагаар нэгд” аян, “Хариуцлагатай уул уурхайн сайн дурын кодекс”-д нэгдсэнээр холбогдох үүрэг, амлалтаа бодитоор хэрэгжүүлэн ажиллаж байна. Компанийн холбогдох тайлангууд, шинэ мэдээ мэдээлэл болон ажлын байртай холбоотой бүхий л мэдээллүүд компанийн болон групп компанийн албан ёсны веб хуудас (www.energyresources.mn; www.mmc.mn) ба нийгмийн сүлжээний хаягуудаар тогтмол нийтлэгддэг.

Мөн бид оролцогч талууд, орон нутгийн иргэдээс Өргөдөл, санал гомдол нээлттэй хүлээн авах хараат бус механизмтай бөгөөд, тухайн жилд хүлээн авсан өргөдөл, санал хүсэлтүүдийн тоо, хэрхэн шийдвэрлэгдсэн талаарх мэдээллийг тайлан, баримт бичгүүдэд тогтмол тусгадаг.



Баянзаг, Булган сум, Өмнөговь аймаг

Тайлагналын олон улсын стандарт (GRI) индекс

GRI 2: Ерөнхий тайлагнал 2021

	Тайлагнах асуудлууд	2025 оны хариулт
Байгууллага болон тайлагналын үйл ажиллагаа		
2-1	Байгууллагын мэдээлэл	Компанийн ерөнхий мэдээлэл
2-2	Байгууллагын тогтвортой байдлын тайлагналд хамрагдсан этгээдүүд	Энэхүү тайланд орсон мэдээллүүд нь групп компанийн хэмжээнд нэгтгэсэн дүн болно.
2-3	Тайлагналын хугацаа, давтамж болон холбогдох этгээд	Тайланг жил бүрийн 5 дугаар сард олон нийтэд тайлагнадаг бөгөөд тус тайланд 2025 оны 1 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх мэдээллийг тусгасан болно. Тайлантай холбоотойгоор холбогдох: contact@mnc.mn
2-4	Мэдээллийн тодруулга	Тодруулга байхгүй
2-5	Хөндлөнгийн баталгаажуулалт	Тогтвортой хөгжлийн тайланд орсон мэдээлэлд хөндлөнгийн байгууллагаар хэсэгчлэн баталгаажуулалт хийлгэдэг.
Үйл ажиллагаа болон ажиллагсад		
2-6	Компанийн үйл ажиллагаа, үнэ цэнэ бүрдүүлэх сүлжээ болон бусад бизнесийн түншлэл	Оршил Ханган нийлүүлэлтийн бодлого ба менежмент
2-7	Ажиллагсад	Ажиллагсад
2-8	Хөдөлмөрийн гэрээт бус ажил гүйцэтгэгчид	Ажиллагсад
Засаглал		
2-9	Засаглалын бүтэц болон бүрэлдэхүүн	Компанийн засаглал Групп компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)
2-10	ТУЗ-ийн гишүүдийн томилгоо болон сонгон шалгаруулалт	Компанийн засаглал Групп компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)
2-11	ТУЗ-ийн дарга	Компанийн засаглал Групп компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)
2-12	Нөлөөллийг удирдахад байгууллагын удирдлагын гүйцэтгэх үүрэг	Тогтвортой хөгжлийн бодлого ба менежмент
2-13	Нөлөөллийг удирдах хариуцлагын хуваарилалт	Тогтвортой хөгжлийн бодлого ба менежмент
2-14	Тогтвортой байдлыг тайлагнахад ТУЗ-ийн оролцоо	Тогтвортой хөгжлийн бодлого ба менежмент Компанийн засаглал
2-15	Ашиг сонирхлын зөрчил	Авлигаас ангид байх зарчим
2-16	Нэн чухал асуудлын харилцаа холбоо	Компанийн засаглал Групп компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)

2-17	ТУЗ-ийн нэгдсэн мэдлэг	Компанийн засаглал Групп компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)
2-18	ТУЗ-ийн гүйцэтгэлийн үнэлгээ	Компанийн засаглал Групп компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)
2-19	Цалин урамшууллын бодлого	Компанийн засаглал Групп компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)
2-20	Цалин урамшууллыг тогтоох процесс	Ажиллагсад Хангамж, урамшууллын бодлого Групп компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)
2-21	Цалин урамшууллын харьцаа	N/A
Бодлого, стратеги, үйл ажиллагаа		
2-22	Тогтвортой хөгжлийн асуудал дээр удирдлагын гаргасан амлалт	Гүйцэтгэх захирлын зурвас
2-23	Бодлогын амлалт	Гүйцэтгэх захирлын зурвас Тогтвортой хөгжлийн бодлого ба менежмент Байгаль орчин Ажиллагсад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
2-24	Бодлогын амлалтын хэрэгжилт	Тогтвортой хөгжлийн бодлого ба менежмент Байгаль орчин Ажиллагсад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
2-25	Сөрөг нөлөөг сааруулах процесс	Оролцогч талуудын хамтын ажиллагаа (Өргөдөл гомдол шийдвэрлэх механизм) Нөхөн сэргээлт ба биологийн олон янз байдал
2-26	Зөвлөгөө авах, асуудал дэвшүүлэх механизм	Ажиллагсад Ёс зүй, хүний эрх
2-27	Хууль болон зохицуулалтын орчны нийцэл	Засаглал Биологийн олон янз байдлын хамгаалал
2-28	Гишүүнчлэл	БОНЗ-ын үнэлгээ, аудит (МУУҮА, CDP, TSM, MSCI, EITI)
Оролцогч талуудын оролцоо		
2-29	Оролцогч талуудын оролцоог хангах хандлага	Оролцогч талуудын хамтын ажиллагаа
2-30	Үйлдвэрчний эвлэл	Ажиллагсад Ёс зүй, хүний эрх

GRI 12: Нүүрсний салбарын стандарт 2022

		Тайлагнах асуудлууд	2025 оны хариулт
12.1.1	Сэдвийн удирдлага	GRI 3: Сэдвүүд 2021 – Тайлагнал 3-3	Эрчим хүчний хэрэглээ ба хэмнэлт
12.1.2	302-1	Байгууллагын дотоод эрчим хүчний хэрэглээ	N/A
12.1.3	302-2	Байгууллагын гаднах эрчим хүчний хэрэглээ	N/A
12.1.4	302-3	Эрчим хүчний хэрэглээний эрчим	Эрчим хүчний хэрэглээ ба хэмнэлт
12.1.5	305-1	Шууд (Score 1) хүлэмжийн хий (GHG) ялгаруулалт	Уур амьсгалын өөрчлөлт ба хүлэмжийн хийн ялгарлын тооцоолол
12.1.6	305-2	Эрчим хүчний шууд бус (Score 2) хүлэмжийн хий (GHG) ялгаруулалт	Уур амьсгалын өөрчлөлт ба хүлэмжийн хийн ялгарлын тооцоолол
12.1.7	305-3	Бусад шууд бус (Score 3) хүлэмжийн хий (GHG) ялгаруулалт	Уур амьсгалын өөрчлөлт ба хүлэмжийн хийн ялгарлын тооцоолол
12.1.8	305-4	Хүлэмжийн хий (GHG) ялгаруулалтын эрчим	Уур амьсгалын өөрчлөлт ба хүлэмжийн хийн ялгарлын тооцоолол
12.2.1	Сэдвийн удирдлага	GRI 3: Сэдвүүд 2021 – Тайлагнал 3-3	Уур амьсгалын өөрчлөлт ба хүлэмжийн хийн ялгарлын тооцоолол
12.2.2	201-2	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй санхүүгийн үр дагавар, эрсдэл, боломжууд	N/A
12.2.3	305-5	Хүлэмжийн хий (GHG) ялгаруулалтыг бууруулах	Уур амьсгалын өөрчлөлт ба хүлэмжийн хийн ялгарлын тооцоолол
12.2.4	Салбарын нэмэлт мэдээлэл	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой олон нийтийн бодлого боловсруулах, лобби хийх үйл ажиллагаа	N/A
12.3.1	Сэдвийн удирдлага	GRI 3: Сэдвүүд 2021 – Тайлагнал 3-3	Байгаль орчин
12.3.2	402-1	Үйл ажиллагааны өөрчлөлтийн талаар урьдчилан мэдэгдэх хамгийн бага хугацаа	IMS.ER.06 Оролцоо, зөвлөлдөөн болон мэдээлэл, харилцаа зохицуулах журам болон IMS.07 Өөрчлөлтийн удирдлагын журмын дагуу зохицуулагд.
12.3.3	404-2	Ажилчдын ур чадварыг сайжруулах, туслах хөтөлбөрүүд	Ажиллагсад
12.3.4	Нэмэлт салбарын мэдээлэл	Хаалт болон нөхөн сэргээх үйл ажиллагаа явуулж буй уурхайн талбайн жагсаалт	Уурхайн үйл ажиллагааны хэмжээнд хэсэгчлэн хаагдсан газар байхгүй.
12.3.5	Нэмэлт салбарын мэдээлэл	Хаалт болон нөхөн сэргээх үйл ажиллагааны санхүүгийн баталгаа	Нөхөн сэргээлт ба ногоон байгууламж
12.3.6	Нэмэлт салбарын мэдээлэл	Хаалт болон нийгэм, эдийн засгийн шилжилтийн санхүүгийн бус баталгаа	Нөхөн сэргээлт ба ногоон байгууламж Оролцогч талуудын хамтын ажиллагаа Орон нутгийн хөгжил ба төсөл, хөтөлбөрүүд

12.4.1	Сэдвийн удирдлага	GRI 3: Сэдвүүд 2021 – Тайлагнал 3-3	Агаарын чанар ба тоосжилт
12.4.2	Салбарын нэмэлт мэдээлэл	Азотын исэл (NOx), хүхрийн исэл (SOx) болон бусад агаарын бохирдлын ялгаруулалт	Агаарын чанар ба тоосжилт
12.5.1	Сэдвийн удирдлага	GRI 3: Сэдвүүд 2021 – Тайлагнал 3-3	Байгаль орчин Нөхөн сэргээлт ба ногоон байгууламж Биологийн олон янз байдлын хамгаалал
12.5.2	304-1	Хамгаалагдсан бүс болон биологийн олон янз байдалтай бүсүүд дотор, ойролцоо, эсвэл тэдгээрийн нөлөөлөлд багтах эзэмшил, түрээсийн болон удирдлагад байгаа үйл ажиллагааны бүсүүд	Байхгүй
12.5.3	304-2 Салбарын нэмэлт мэдээлэл	Байгууллагын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээнээс биологийн олон янз байдалд үзүүлэх томоохон нөлөөлүүд	Нөхөн сэргээлт ба ногоон байгууламж Биологийн олон янз байдлын хамгаалал
12.5.4	304-3	Хамгаалсан болон нөхөн сэргээсэн экосистем, амьдрах орчин (habitat)	Нөхөн сэргээлт ба ногоон байгууламж
12.5.5	304-4	IUCN-ийн Улаан жагсаалтад орсон болон үндэсний хамгаалалтын жагсаалтад багтсан төрөл зүйлийн амьтан, ургамал	Төслийн үйл ажиллагааны шууд нөлөөлөлд өртөж байгаа олон улс, бүс нутаг, үндэсний улаан дансанд орсон биологийн төрөл зүйл байхгүй болно.
12.6.1	Сэдвийн удирдлага	GRI 3: Сэдвүүд 2021 – Тайлагнал 3-3	Хог хаягдлын менежмент
12.6.2	306-1	Хог хаягдал болон түүнтэй холбоотой голлох үр нөлөө	Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын дотоод журам үйл ажиллагаанд тогтмол мөрдөгддөг
12.6.3	306-2	Хог хаягдал болон түүнтэй холбоотой голлох үр нөлөөллийн менежмент	Хог хаягдлын менежмент
12.6.4	306-3	Үүссэн хог хаягдал	Хог хаягдлын менежмент Аюултай хог хаядал
12.6.5	306-4	Хог хаягдлыг шууд хаялгүйгээр дахин ашигласан байдал, хог хаягдлын нийт жин (метрик тонн) болон хаягдлын бүрэлдэхүүний задаргаа	Хог хаягдлын менежмент Аюултай хог хаядал
12.6.6	306-5	Устгалд оруулсан хог хаягдал (хогийн цэг, шатаасан, аюултай)	Хог хаягдлын менежмент Аюултай хог хаядал
12.7.1	Сэдвийн удирдлага	GRI 3: Сэдвүүд 2021 – Тайлагнал 3-3	Усны менежмент
12.7.2	303-1	Усны нөөцийн ашиглалт	Усны менежмент
12.7.3	303-2	Ус зайлуулалттай холбоотой нөлөөллийн менежмент (мөрддөг стандарт, дүрэм журам)	Усны менежмент

12.7.4	303-3	Байгалийн эх үүсвэрээс олборлосон усны нийт хэмжээ	Усны менежмент
12.7.5	303-4	Хаяж зайлуулсан бохир усны нийт хэмжээ, төрлөөр	Усны менежмент
12.7.6	303-5	Нийт усны хэрэглээ	Усны менежмент
12.8.1	Сэдвийн удирдлага	GRI 3: Сэдвүүд 2021 – Тайлагнал 3-3	Ажиллагсад Ханган нийлүүлэлтийн бодлого ба менежмент Орон нутгийн хөгжил ба төсөл, хөтөлбөрүүд
12.8.2	201-1	Бий болгосон болон хуваарилсан шууд эдийн засгийн өгөөж	\$ 1,572,584,000
12.8.3	202-2	Орон нутгийн иргэдээс ажилд авсан удирдах түвшний ажилчдын хувь	Ажиллагсад
12.8.4	203-1	Дэд бүтцийн хөрөнгө оруулалт болон дэмжих үйлчилгээ	\$ 6,773,000
12.8.5	203-2	Шууд бус томоохон эдийн засгийн нөлөөлөл	Үйл ажиллагаа явуулж буй орон нутагт, шууд үйл ажиллагаа болон төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнд хамрагдагч иргэдийн тоо багадаа +10,000
12.8.6	204-1	Орон нутгийн ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь	Ханган нийлүүлэлтийн бодлого ба менежмент
12.9.1	Сэдвийн удирдлага	GRI 3: Сэдвүүд 2021 – Тайлагнал 3-3	Оролцогч талуудын хамтын ажиллагаа Орон нутгийн хөгжил ба төсөл, хөтөлбөрүүд
12.9.2	413-1	Орон нутгийн иргэдийн оролцоотой үйл ажиллагаа, нөлөөллийн үнэлгээ болон хөгжлийн хөтөлбөрүүд	Орон нутгийн хөгжил ба төсөл, хөтөлбөрүүд
12.9.3	413-2	Орон нутгийн иргэдэд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байгаа болон үзүүлэх эрсдэлтэй үйл ажиллагаанууд	Байгаль орчин Нийгэм
12.9.4	Нэмэлт салбарын мэдээлэл	Орон нутгийн иргэдээс ирүүлсэн санал, гомдлууд	Оролцогч талуудын хамтын ажиллагаа
12.10.1	Сэдвийн удирдлага	GRI 3: Сэдвүүд 2021 – Тайлагнал 3-3	Оролцогч талуудын хамтын ажиллагаа Орон нутгийн хөгжил ба төсөл, хөтөлбөрүүд
12.10.2	Нэмэлт салбарын мэдээлэл	Албадан нүүлгэн шилжүүлэлтэд хүргэхүйц уурхайн үйл ажиллагаа	Байхгүй
12.11.1	Сэдвийн удирдлага	GRI 3: Сэдвүүд 2021 – Тайлагнал 3-3	N/A
12.11.2	411-1	Нутгийн уугуул иргэдийн эрх ашгийг зөрсөн тохиолдлууд бий эсэх	N/A
12.11.3	Салбарын нэмэлт мэдээлэл	Уугуул иргэдэд нөлөөлөх үйл ажиллагаа бий эсэх	N/A

12.11.4	Салбарын нэмэлт мэдээлэл	Нээлттэй, чөлөөт байдлаар мэдээллийг урьдчилан түгээх, харилцах	N/A
12.12.1	Сэдвийн удирдлага	GRI 3: Сэдвүүд 2021 – Тайлагнал 3-3	Ажиллагсад
12.12.2	410-1	Аюулгүй байдал, хамгаалалтын ажилчдад хүний эрхийн бодлого, журамтай холбоотой сургалт олгосон байдал	Ажиллагсад
12.13.1	Сэдвийн удирдлага	GRI 3: Сэдвүүд 2021 – Тайлагнал 3-3	Хог хаягдлын менежмент
12.13.2	306-3	Бодис асгаралтын ноцтой тохиолдол бий эсэх	Хог хаягдлын менежмент
12.13.3	Салбарын нэмэлт мэдээлэл	Ноцтой осол, зөрчлүүд ба тэдгээрийн нөлөөлөл	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
12.13.4	Салбарын нэмэлт мэдээлэл	Хаягдлын байгууламжийн менежмент ба шаардлагын хэрэгжилт	Хог хаягдлын менежмент
12.14.1	Сэдвийн удирдлага	GRI 3: Сэдвүүд 2021 – Тайлагнал 3-3	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
12.14.2	403-1	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
12.14.3	403-2	Аюулыг тодорхойлох, эрсдэлийг үнэлэх болон осол, зөрчлийг судлах ажиллагаа	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
12.14.4	403-3	Хөдөлмөрийн эрүүл мэндийн үйлчилгээ	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
12.14.5	403-4	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын чиглэлээр ажилчдын оролцоо, зөвлөлдөх, харилцах ажиллагаа	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
12.14.6	403-5	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын сургалт	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
12.14.7	403-6	Ажилчдын эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
12.14.8	403-7	Бизнесийн харилцаатай шууд холбоотой хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
12.14.9	403-8	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоонд хамрагдсан ажилчид	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
12.14.10	403-9	Хөдөлмөрийн үйл ажиллагаатай холбоотой гэмтэл, бэртэл	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
12.14.11	403-10	Хөдөлмөрийн үйл ажиллагаатай холбоотой өвчлөл	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
12.15.1	Сэдвийн удирдлага	GRI 3: Сэдвүүд 2021 – Тайлагнал 3-3	Ажиллагсад

12.15.2	401-1	Шинээр ажилд орсон болон ажлаас гарсан ажилчдын тоо	Ажиллагсад
12.15.3	401-2	Зөвхөн үндсэн ажилчдад олгодог нэмэлт хангамжууд	Ажиллагсад
12.15.4	401-3	Эцэг эхийн чөлөө (дикрит)	Ажиллагсад
12.15.5	402-1	Үйл ажиллагааны өөрчлөлтийн талаар ажилчдад урьдчилан мэдэгдэх доод хугацаа	IMS.ER.06 Оролцоо, зөвлөлдөөн болон мэдээлэл, харилцаа зохицуулах журам болон IMS.07 Өөрчлөлтийн удирдлагын журмын дагуу зохицуулагд.
12.15.6	404-1	Нэг ажилчинд жилд ногдох сургалтын дундаж цаг	Ажиллагсад
12.15.7	404-2	Ажилчдын ур чадварыг дээшлүүлэх болон ажлын шилжилтэд туслах хөтөлбөрүүд	Ажиллагсад
12.15.8	414-1	Нийгмийн шалгуурын дагуу үнэлгээ хийсэн шинэ ханган нийлүүлэгчид	Ханган нийлүүлэлтийн бодлого ба менежмент
12.15.9	414-2	Нийлүүлэлтийн сүлжээн дэх сөрөг нийгмийн нөлөөлөл ба авсан арга хэмжээ	N/A
12.16.1	Сэдвийн удирдлага	GRI 3: Сэдвүүд 2021 – Тайлагнал 3-3	Ажиллагсад
12.16.2	408-1	Хүүхдийн хөдөлмөр эрхлүүлэх эрсдэл өндөртэй үйл ажиллагаа болон ханган нийлүүлэгчид	Ажиллагсад
12.16.3	414-1	Нийгмийн шалгуураар үнэлж, шалгаруулсан шинэ ханган нийлүүлэгчид	Ханган нийлүүлэлтийн бодлого ба менежмент
12.17.1	Сэдвийн удирдлага	GRI 3: Сэдвүүд 2021 – Тайлагнал 3-3	Ажиллагсад
12.17.2	409-1	Албадан хөдөлмөр эрхлүүлэх эрсдэл өндөртэй үйл ажиллагаа болон ханган нийлүүлэгчид	Ажиллагсад
12.17.3	414-1	Нийгмийн шалгуур үзүүлэлтээр үнэлж, сонгосон шинэ ханган нийлүүлэгчид	Ханган нийлүүлэлтийн бодлого ба менежмент
12.18.1	Сэдвийн удирдлага	GRI 3: Сэдвүүд 2021 – Тайлагнал 3-3	Нийгэм
12.18.2	407-1	Ажилчид болон ханган нийлүүлэгчдийн нэгдэн нийлэх, хамтын хэлэлцээ хийх эрх нь эрсдэлд байгаа эсэх	Ажиллагсад
12.19.1	Сэдвийн удирдлага	GRI 3: Сэдвүүд 2021 – Тайлагнал 3-3	Ажиллагсад
12.19.2	202-1	Хүйсийн ялгамжаатай ажилд шинээр орогчдын цалинг улсын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй харьцуулсан харьцаа	N/A
12.19.3	202-2	Орон нутгаас сонгогдсон дээд шатны удирдах албан тушаалтнуудын эзлэх хувь	Ажиллагсад

12.19.4	401-3	Эцэг эхийн чөлөө	Ажиллагсад
12.19.5	404-1	Нэг ажилчинд жилд ногдох сургалтын дундаж цаг	Ажиллагсад
12.19.6	405-1	Удирдлагын болон ажилчдын олон талт байдал	Ажиллагсад Компанийн засаглал
12.19.7	405-2	Эмэгтэй, эрэгтэй ажилчдын үндсэн цалин болон урамшууллын харьцаа	Ажиллагсад
12.19.8	406-1	Ялгаварлан гадуурхалтын тохиолдлууд болон авч хэрэгжүүлсэн залруулах арга хэмжээ	Ялгаварлан гадуурхалтын тохиолдол бүртгэгдээгүй.
12.20.1	Сэдвийн удирдлага	GRI 3: Сэдвүүд 2021 – Тайлагнал 3-3	Авлигаас ангид байх зарчим
12.20.2	205-1	Авлигын эрсдэлийн үнэлгээ хийсэн үйл ажиллагаанууд	Авлигаас ангид байх зарчим
12.20.3	205-2	Авлигын эсрэг бодлого, журмын талаархи харилцаа холбоо ба сургалт	Авлигаас ангид байх зарчим
12.20.4	205-3	Илэрсэн авлигын тохиолдлууд болон авсан арга хэмжээ	Авлигаас ангид байх зарчим
12.20.5	Салбарын нэмэлт мэдээлэл	Эцсийн өмчлөгчдийн ил тод байдал	Эцсийн өмчлөгчийн мэдээлэл Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим хуудсанд нээлттэй байрлаж байна.
12.20.6	Салбарын нэмэлт мэдээлэл	Гэрээний ил тод байдал	Засгийн газар болон түүнийг төлөөлөх эрх бүхий байгууллагатай байгуулсан хөрөнгө оруулалт болон тогтвортой байдлын гэрээний мэдээлэл нь "Ашигт малтмалын хайгуул болон олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тайлан"-д байршдаг.
12.21.1	Сэдвийн удирдлага	GRI 3: Сэдвүүд 2021 – Тайлагнал 3-3	Компанийн мэдээлэл
12.21.2	201-1	Шууд бий болгосон болон хуваарилсан эдийн засгийн үнэ цэнэ	\$ 1,572,584,000
12.21.3	201-4	Засгийн газраас хүлээн авсан санхүүгийн дэмжлэг	N/A
12.21.4	207-1	Татварт хандах бодлого, арга барил	N/A
12.21.5	207-2	Татварын удирдлага, хяналт ба эрсдэлийн менежмент	N/A
12.21.6	207-3	Татвартай холбоотой асуудлаар оролцогч талуудтай харилцах, санал гомдлыг удирдах арга барил	N/A
12.21.7	207-4	Улс бүрээр тайлагнах	Компанийн мэдээлэл
12.21.8	Салбарын нэмэлт мэдээлэл	Төрийн өмчит нүүрсний худалдан авалттай холбоотой төлбөрүүд	N/A
12.22.1	Сэдвийн удирдлага	GRI 3: Сэдвүүд 2021 – Тайлагнал 3-3	N/A
12.22.2	415-1	Улс төрийн хандивууд	Байхгүй

5.2 БОНЗ тогтвортой байдлын тайлагналын удирдамж

	MS – Менежментийн системтэй холбоотой үзүүлэлтүүд	2025 оны хариулт
MS1.1	Танай компанийн удирдлагын зүгээс тогтвортой хөгжлийн асуудлаар авсан амлалт/хийсэн мэдэгдэл бий юу? (Тийм/Үгүй)	Гүйцэтгэх захирлын зурвас
MS2.1	Танай компани тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудаа баталсан уу? (Тийм/Үгүй)	Тогтвортой хөгжлийн бодлого ба менежмент
MS2.2	Танай компани тогтвортой хөгжлийн талаар баримтлах дүрэм, журам бий юу? (Тийм/Үгүй)	Тогтвортой хөгжлийн бодлого ба менежмент
MS3.1	Танай компанид тогтвортой хөгжлийн асуудлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн хариуцсан тусгай хороод бий юу? (Тийм/Үгүй)	Тогтвортой хөгжлийн бодлого ба менежмент
MS3.2	Танай компанийн ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил/БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн/ гишүүд (бүтэн цагийн/хавсран ажилладаг) бий юу? (Тийм/Үгүй)	Тогтвортой хөгжлийн бодлого ба менежмент
MS3.3	Танай компанийн Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил/БОНЗ-ын асуудал хариуцсан захирал/захирлууд (бүтэн цагийн/хавсран ажилладаг) бий юу? (Тийм/Үгүй)	Тогтвортой хөгжлийн бодлого ба менежмент
MS3.4	Танай компанийн Үйл ажиллагааны түвшинд тогтвортой хөгжил/БОНЗ-ын асуудал хариуцсан ажилтан/ажилтнууд (бүтэн цагийн/хавсран ажилладаг) бий юу? (Тийм/Үгүй)	Тогтвортой хөгжлийн бодлого ба менежмент
MS3.5	Танай компанийн ТУЗ-ийн хурлын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн асуудлыг тогтмол, албан ёсоор тусгадаг уу? (Тийм/Үгүй)	Тогтвортой хөгжлийн бодлого ба менежмент
MS4.1	Эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, улмаар эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх талаар хийсэн материаллаг байдлын процесс, үнэлгээ, матриц танай компанид бий юу? (Тийм/Үгүй)	БОНЗ-ын материаллаг байдлын үнэлгээ
MS5.1	Нэг ажилтанд ногдох тогтвортой хөгжлийн асуудлаарх сургалтад жилд зарцуулсан дундаж хугацаа (цаг ба хүйсээр)	N/A
MS6.1	Аудитын хороо (эсвэл ижил төстэй удирдах зөвлөлийн хороо)-ны хийх ажлын хүрээ, дотоод хяналтын чиг үүрэгт тогтвортой хөгжлийн асуудалд хамаардаг уу?	Тийм Тогтвортой хөгжлийн бодлого ба менежмент
MS7.1	Танай компани тогтвортой байдлын тайланг (тусгайлан/буюу жилийн тайланд нэгтгэж) хамгийн багадаа жилд нэг удаа гаргадаг уу? (Тийм/Үгүй)	Тийм
MS7.2	Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх олон улсын стандарт (TCFD & TNF-D)-ын дагуу тайлагнадаг уу? (Тийм/Үгүй)	Групп компанийн 2025 оны тайлангийн 50-р хуудсанд TCFD-ийн талаар мэдээлэл тусгагдсан болно.

MS7.3	Тогтвортой байдлын талаарх мэдээлэлдээ хараат бус гуравдагч этгээдээр баталгаа гаргуулдаг уу? (Тийм/Үгүй)	Компани хүлэмжийн хийн ялгаруулалтын хэмжээг Сингапурын SGS олон улсын баталгаажуулалтын байгууллагаар хянуулан баталгаажуулж, холбогдох гэрчилгээ авсан.
MS8.1	Танай компани тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг (бизнес, хүний эрх гэх мэт) олон улсын болон дотоодын холбоо, нэгдэлтэй нэгдэж хамтран ажилладаг уу?	БОНЗ-ын үнэлгээ, аудит
E – Байгаль орчинтой холбоотой үзүүлэлтүүд		
E1.1	Эрчим хүчний нийт зарцуулалтын хэмжээ (кВтц) болон зардал (төг)	Эрчим хүчний хэрэглээ ба хэмнэлт
E1.2	Цахилгаан эрчим хүчний нийт хэрэглээ (кВтц), зардал (төг), хэмнэлт (өмнөх жилийн мөн үетэй харьцуулснаар)	Эрчим хүчний хэрэглээ ба хэмнэлт
E1.3	Дулааны эрчим хүчний нийт хэрэглээ (Гкал, Гдж), зардал (төг), хэмнэлт (өмнөх жилийн мөн үетэй харьцуулснаар)	N/A
E1.4	Түлшний нийт хэрэглээ (нүүрс, газрын тос, байгалийн хий гэх мэт) (Литр, Гдж), зардал (төг), хэмнэлт (өмнөх жилийн мөн үетэй харьцуулснаар)	N/A
E1.5	Сэргээгдэх эрчим хүч (СЭХ)-нээс бусад буюу хүрэн эх үүсвэрээс авсан эрчим хүчний хэрэглээний хувийн жин (%)	100%
E1.6	СЭХ хэрэглээний хувийн жин, СЭХ эх үүсвэрийн төрөл (%)	Байхгүй
E2.1	Компанийн шууд (Score 1) болон шууд бус (Score 2) үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн нийт ялгарал (метр тонн CO2-экв)	Уур амьсгалын өөрчлөлт ба хүлэмжийн хийн ялгарлын тооцоолол
E2.2	Компанийн шууд (Score 1) болон шууд бус (Score 2) үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлын нийт бууралт (метр тонн CO2-экв)	Уур амьсгалын өөрчлөлт ба хүлэмжийн хийн ялгарлын тооцоолол
E2.3	Нийт карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээний үр дүнд бууруулсан нүүрсхүчлийн хийн ялгаруулалт (метр тонн CO2-экв)	Байхгүй
E3.1	Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар тусгайлсан эсвэл бусад журамд нэгтгэсэн бодлого бий юу? (Тийм/Үгүй)	Компанид тогтвортой хөгжлийн нэгдсэн бодлого одоогоор байхгүй бөгөөд Тогтвортой хөгжлийн хүрээний баримт бичгийг боловсруулах үйл явц үргэлжилж байна.
E3.2	Танай компани уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх эрсдэл болон боломжийн талаар үнэлгээ (олон хувилбартай дүн шинжилгээ, стресс тест гэх мэт) хийсэн үү? (Тийм/Үгүй)	Байгаль орчин
E3.3	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, онцгой тохиолдлуудын улмаас учирсан эдийн засгийн нийт хохирлын хэмжээ (төг)	Байхгүй

E3.4	Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд чиглэсэн дэд бүтэц, дасан зохицох, бүтээгдэхүүн хөгжүүлэх зэрэг үйл ажиллагаанд жилд оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн (төг)	N/A
E3.5	Танай компани уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор ашигт ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол) дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ/ алхмуудыг тодорхойлсон уу? (Тийм/Үгүй)	Тийм
E4.1	Ашигласан усны нийт хэмжээ (Л, м³), эх үүсвэрээр	Усны менежмент
E4.2	Хэмнэлт, үр ашгийг дээшлүүлснээр нийт хэмнэсэн/дахин боловсруулсан усны хэмжээ (Л, м³)	Усны менежмент
E4.3	Дахин ашигласан болон боловсруулсан усны эзлэх хувь (%)	Усны менежмент
E4.4	Хаяж зайлуулсан бохир усны нийт хэмжээ (Л, м³)	Усны менежмент
E5.1	Ялгаруулсан нийт хог хаягдлын хэмжээ, төрлөөр, устгалын аргаар (тонн)	Хог хаягдлын менежмент
E5.2	Хог хаягдлын дахин боловсруулалтын хувь (%)	Хог хаягдлын менежмент
E5.3	Хортой хог хаягдал (цахилгаан хэрэгслийн хог хаягдал ороод) (тонн)	Хог хаягдлын менежмент
E6.1	Байгаль орчны хувьд тогтвортой ашиглаж буй нийтийн эзэмшлийн талбай буюу барьсан ногоон байгууламжийн талбайн нийт талбайд эзлэх хувь (%)	Ногоон байгууламж ба ойжуулалт
E6.2	Хамгаалагдсан төрөл зүйлийн тоо	Нөхөн сэргээлт ба биологийн олон янз байдал
E6.3	Тусгай хамгаалалттай газар нутаг, биологийн олон янз байдал, соёлын үнэ цэнэ өндөртэй газар нутгийг эзэмшиж, түрээсэлсэн, удирдаж байгаа эсвэл зэргэлдээх үйл ажиллагааны талбайн нийт талбайд эзлэх хувь	Нөхөн сэргээлт ба биологийн олон янз байдал
S – Нийгмийн үзүүлэлтүүд		
S1.1	Өмнөх жилийнхээс өөрчлөгдсөн үндсэн ажилтнуудын хувийн жин (%)	24.80%
S1.2	Өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад шинээр нэмэгдсэн үндсэн ажилтнуудын хувийн жин (%)	Ажиллагсад
S1.3	Нэг ажилтанд ногдох сургалтын жилийн дундаж хугацаа (цаг)	Ажиллагсад
S2.1	Танай компанид ХАБЭА-н бодлого, журам (тусгайлсан эсвэл бусад журамд нэгтгэсэн) бий юу? (Тийм/Үгүй)	Нийгэм
S2.2	Ажил үүрэгтэй холбоотойгоор жилд гарсан осол гэмтлийн тохиолдол, хувиар (%)	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

S2.3	Нэг ажилтанд ногдох ХАБЭА-н сургалтын жилийн дундаж хугацаа (цаг)	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
S2.4	Эрүүл мэндийн үзлэг, сайн дурын эрүүл мэндийн хөтөлбөрт хамрагдсан ажилтнуудын тоо	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
S3.1	Танай компанид Жөндөрийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)? (Тийм/Үгүй)	Тийм
S3.2	Танай компанид Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)? (Тийм/Үгүй)	Ажиллагсад
S3.3	Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?(Тийм/Үгүй)	Ажиллагсад
S3.4	Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын эзлэх хувийн жин (%)	Ажиллагсад
S3.5	Удирдах зөвлөлд эрэгтэй, эмэгтэй гишүүдийн эзлэх хувийн жин (%)	Ажиллагсад
S3.6	Гүйцэтгэх удирдлагын түвшинд эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин (%)	Ажиллагсад
S3.7	Дунд болон анхан шатны нэгж дэх эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын хувийн жин (%)	Ажиллагсад
S3.8	Эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа	Ажиллагсад
S4.1	Та компанид Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан олон нийтэд нээлттэй бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)? (Тийм/Үгүй)	Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулинд заасан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөрлөх боломжоор хангах, түүнтэй холбоотой зохицуулалтуудыг дагаж мөрддөг.
S4.2	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийт ажилтны тоонд эзлэх хувь (%)	1.0%
S4.3	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ээлтэй хүртээмжтэй орчин бүрдүүлсэн ажлын байр, байгууламж бий юу? (Тийм/Үгүй)	Тийм
S4.4	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөөгүйн улмаас төлсөн торгуулийн хэмжээ (төг)	Ажиллагсад
S5.1	Танай компанид удирдлагаас баталсан оролцогч талуудтай хамтарч ажиллах талаар тусгайлсан бодлого байгаа юу? (Тийм/Үгүй)	Оролцогч талуудын хамтын ажиллагаа
S5.2	Танай компанид нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ хийх болон газар чөлөөлөлтийн асуудлаарх бодлого журам бий юу? (Тийм/Үгүй)	Тийм
S5.3	Танай компанид гомдол маргаан шийдвэрлэх бодлого, механизм бий юу? (Тийм/Үгүй)	Оролцогч талуудын хамтын ажиллагаа Өргөдөл гомдол шийдвэрлэх механизм
S5.4	Танай компанийн үйл ажиллагаа нөлөөлж буй иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу? (Тийм/Үгүй)	Оролцогч талуудын хамтын ажиллагаа Өргөдөл гомдол шийдвэрлэх механизм

S5.5	Олон нийтээс хүлээн авч i) шийдвэрлэж байгаа ii) шийдвэрлэсэн санал гомдлын хувь (%)	Оролцогч талуудын хамтын ажиллагаа
S5.6	Олон нийтэд чиглэсэн нийгмийн хариуцлагын арга хэмжээ, хөтөлбөрүүдэд зарцуулсан зардлын нийт орлогод эзлэх хувь, ТХЗ-ын ангиллаар (%)	Оролцогч талуудын хамтын ажиллагаа
S6.1	Танай компанид дотоодын худалдан авалт болон тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжийг хангасан худалдан авалтын бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)? (Тийм/Үгүй)	Ханган нийлүүлэлтийн бодлого ба менежмент
S6.2	Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь (%)	Ханган нийлүүлэлтийн бодлого ба менежмент
S6.3	Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчдийн хувь (%)	17%
G – Засаглалын үзүүлэлтүүд		
G1.1	Танай компани шинээр батлагдсан Кодексийн дагуу компанийн засаглалын бодлого, журам бий юу, тайлагнал хийдэг үү? (Тийм/Үгүй)	Үгүй
G1.2	Удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн хувийн жин (%)	Компанийн засаглал
G1.3	Танай компанид жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах дүрэм, журам бий юу? (Тийм/Үгүй)	Тийм
G2.1	Танай компанид авлигын эсрэг бодлого болон/ буюу ёс зүйн дүрэм, журам бий юу? (Тийм/Үгүй)	Авлигаас ангид байх зарчим
G2.2	Танай компанид нийцлийн бодлого, журам бий юу? (Тийм/Үгүй)	Тийм
G2.3	Танай компанид комплаенсын хөтөлбөр (ажилнуудад зориулсан сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн тухай мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хориг тавих зэрэг асуудлаарх заавар, журам гэх мэт) бий юу? (Тийм/Үгүй)	Авлигаас ангид байх зарчим
MI – Уул уурхайн салбарын нэмэлт үзүүлэлтүүд		
MI.1	Нийт ашиглалтын зориулалттай газартай харьцуулахад нөхөн сэргээлт хийсэн газрын талбайн хувь	Байгаль орчин Нөхөн сэргээлт ба биологийн олон янз байдал
MI.2	Байгаль орчны тусгай зөвшөөрөл, стандартууд, дүрэм журмыг дагаж мөрдөөгүйтэй холбоотой үүссэн зөрчлийн тоо	Байхгүй
MI.3	Эдийн засгийн шилжилт хөдөлгөөн, нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүмүүсийн тоо	Байхгүй

A herd of camels is grazing in a vast, open landscape. The camels are scattered across the scene, with some in the foreground and others further back. The terrain is a mix of green grass and brown, sandy soil. The sky is a clear, pale blue. The overall scene is peaceful and natural.

Энержи Ресурс компани:

Утас: 7012 2279

Факс: 11 322279

Веб: www.energyresources.mn

16 давхар, Сентрал тауэр

Сүхбаатарын талбай

Улаанбаатар 14200

Ухаа худаг уурхай

Өмнөговь аймаг

Цогтэций сум, Өгөөмөр баг

Утас: 7712 2304